

# ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Барилга, хот байгуулалтын яам

2019 оны жилийн эцсийн байдлаар

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО</b>							
1	1.9. “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад үнэлэлт, дүгнэлт өгч, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ.	1. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалт, зээлийн эргэн төлөлт, чанарын судалгааг хийх, дүгнэлт гарах	2017			“Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг үе шаттай гүйцэтгэсэн. Үүнд: БХБСайдын 2013.01.09-ний өдрийн А-2/06 дугаар тушаалаар баталсан “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр болон “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийг дэмжих зорилгоор 2013-2016 онд Хөгжлийн банкнаас 72 аж ахуйн нэгжид 195,2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/53 дугаар тушаалаар дээрх зээлд хамрагдсан барилгын материалын үйлдвэрлэлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. ХШҮ-нд нийт 77 аж ахуйн нэгж /нийслэлд 57, аймагт 20 аж ахуйн нэгж/-ийг хамруулсан бөгөөд хэрэгжилт 70%-тай байсан. ХШҮ-ний ажлын тайланг БХБСайдын Зөвлөлийн хуралдаанд 2018.04.17-ны өдөр танилцуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2018.09.19-ний өдрийн А/161 дугаар тушаалаар дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд зээл авсан төслүүдийн хэрэгжилтэд ХШҮ хийх ажлын хэсгийг дахин байгуулж, батлагдсан удирдамжийн дагуу Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад ажилласан. Эдгээр аймгуудын ГХБХБГазруудын холбогдох дарга, мэргэжилтнүүдтэй уулзан, аймгийн хэмжээнд эргэлтийн хөрөнгийн зээл авсан барилгын материалын үйлдвэрүүдийн судалгааг гарган, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр зэрэг үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, зээлийн үр ашиг, зарцуулалтыг сайжруулах зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан. ХШҮ-ний тайланг яамны удирдлагуудад танилцуулсан. Дээрх хөтөлбөрийн хүрээнд Бэрэн группын гангийн үйлдвэрт 73,8 тэрбум төгрөгийн зээлийг Хөгжлийн банкнаас олгосон. ”Монгол	100%

					<p>базальт” ХХК, “Баярс” ХХК, “Дархан хөвөн” ХХК, “Инжир” ХХК-ийн үйлдвэрүүдийг яамнаас бодлогоор дэмжин, Хөгжлийн банкинд зээлийн хүсэлтийг уламжилсан. 2019 онд “Лэл минерал” ХХК, “Дархан анд” ХХК-ын ган туйвангийн үйлдвэрүүд ашиглалтад орсноор дотоодын үйлдвэрлэл 20%-аар нэмэгдсэн.</p> <p>Хавсралт : 4 файл</p>	
2	<p>1.10.Хөгжлийн банкны бонд, зээлийн зарцуулалтыг дүгнэж, төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлнэ.</p>	<p>1. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн батлуулах, төслүүдэд үнэлгээ хийж, эрсдэлийг тооцоолох, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаарх арга хэмжээг холбогдох гэрээнд заасны дагуу үе шаттай авч хэрэгжүүлэх</p>	2016 - 2020		<p>“Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг үе шаттай гүйцэтгэсэн. Үүнд: БХБСайдын 2013.01.09-ний өдрийн А-2/06 дугаар тушаалаар баталсан “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр болон “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийг дэмжих зорилгоор 2013-2016 онд Хөгжлийн банкнаас 72 аж ахуйн нэгжид 195,2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/53 дугаар тушаалаар дээрх зээлд хамрагдсан барилгын материалын үйлдвэрлэлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. ХШҮ-нд нийт 77 аж ахуйн нэгж /нийслэлд 57, аймагт 20 аж ахуйн нэгж/-ийг хамруулсан бөгөөд хэрэгжилт 70%-тай байсан. ХШҮ-ний ажлын тайланг БХБСайдын Зөвлөлийн хуралдаанд 2018.04.17-ны өдөр танилцуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2018.09.19-ний өдрийн А/161 дугаар тушаалаар дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд зээл авсан төслүүдийн хэрэгжилтэд ХШҮ хийх ажлын хэсгийг дахин байгуулж, батлагдсан удирдамжийн дагуу Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад ажилласан. Эдгээр аймгуудын ГХБХБГазруудын холбогдох дарга, мэргэжилтнүүдтэй уулзан, аймгийн хэмжээнд эргэлтийн хөрөнгийн зээл авсан барилгын материалын үйлдвэрүүдийн судалгааг гарган, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр зэрэг үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, зээлийн үр ашиг, зарцуулалтыг сайжруулах зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан. ХШҮ-ний тайланг яамны удирдлагуудад танилцуулсан. Дээрх хөтөлбөрийн хүрээнд Бэрэн группын гангийн үйлдвэрт 73,8 тэрбум төгрөгийн зээлийг Хөгжлийн банкнаас олгосон. “Монгол базальт” ХХК, “Баярс” ХХК, “Дархан хөвөн” ХХК, “Инжир” ХХК-ийн үйлдвэрүүдийг яамнаас бодлогоор дэмжин, Хөгжлийн банкинд зээлийн хүсэлтийг уламжилсан. 2019 онд “Лэл минерал” ХХК, “Дархан анд” ХХК-ын ган туйвангийн үйлдвэрүүд ашиглалтад орсноор дотоодын үйлдвэрлэл 20%-аар нэмэгдсэн. Хавсралт : 1 файл</p>	100%

3	1.19.Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана.	1. Барилга үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн журмыг шинэчлэн, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2017		Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 217 дугаар тушаалаар "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам"-ыг шинэчлэн батлуулсан. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 33 дугаар тушаалаар "Аргачлал батлах тухай" журам батлагдсан. ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд 2019 оны 1 дүгээр сарын 24-ний 4180 дугаарт бүртгүүлж, батлагдсан дүрэм, журмуудыг мөрдөн ажиллаж байна. Барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралт, барилгын материалын тусгай зөвшөөрөл олгох комиссын үйл ажиллагааг салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлсэн. 2019 онд нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан 1500 гаруй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг тухай бүр мэдээллээр ханган ажилласан байна. "Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" шинээр авах, нэмэлт ажил авах, сунгуулах, ИТА хасалт хийлгэх, нэмж бүртгүүлэх, тодорхойлолт хүсэх зэрэг 1402 албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэн хүлээн авсан. Үүнээс: давхардсан тоогоор тусгай зөвшөөрлийн хүсэлт 918, инженер техникийн ажилчдын шилжилт хөдөлгөөн болон тодорхойлолт хүссэн 469, бусад төрлөөр 15 албан бичиг ирсэн бөгөөд эдгээр асуудал бүрд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Хавсралт : 1 файл	100%
4		2. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах	2017		Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдлийг цахимаар болон цаасан хэлбэрээр авч байсан бөгөөд 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн <a href="http://www.tz.mnса.mn">www.tz.mnса.mn</a> сайтаар цахимаар хүлээн авч шийдвэрлэж эхлээд байна. "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	100%

					олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид тавих шаардлага, бүртгэх журам"-ын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн 1000 аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл материалыг хүлээн авч судлан "Тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсэг"-ийн 15 удаагийн хурлыг хийж холбогдох асуудлуудыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлээд байна. Хавсралт : 1 файл	
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО</b>						
5	2.11.Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.	3. Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	2017 - 2020		Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ-д хийх албан ёсны айлчлалын үеэр болох хэлэлцээр, уулзалтын сэдэвт 2018.02.14-ны өдрийн 01/551 тоот албан бичгээр, Замын-Үүдийн чөлөөт бүсэд Хятадын талаас хөрөнгө оруулалт татах, зохих бэлтгэл хангасан төслүүдийг хэрэгжүүлэх, "Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хүчин чадлын хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зарчмын хувьд дэмжиж, "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл" -ийн 2 дугаар үе шат , Замын-Үүд чөлөөт бүсийн 200 га-д үйлдвэрлэлийн парк байгуулах төсөл, Барилгын материалын импортын нэгдсэн хангамж, сорил шинжилгээний лаборатори, авто тээврийн логистик цогцолбор, Замын-Үүд Эрээний хил дамнасан чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хамтарч боловсруулах төсөл зэргийг 2017.08.07-ны өдрийн 04/2281 тоот, 2018.02.15-ны өдрийн 01/573 тоот албан бичгээр ГХЯ-д тус тус хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий Сайд У.Хүрэлсүх 2018.04.09-ний өдөр БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр Бээжин хотноо холбогдох хэлэлцээрүүд байгуулагдсан болно. 2018 онд Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдахад шаардлагатай санхүүжилтийн гадаад эх үүсвэр шийдэгдээгүй тул тус ажил удаашралтай байна. Хавсралт : 4 файл	40%
6		5. Барилгын материал, техник, тоног төхөөрөмж зэргийн бөөний худалдааны сүлжээг Алтанбулаг, Замын-Үүд, Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд байгуулах	2017 - 2020		Замын-Үүдийн чөлөөт бүсэд барилгын материалын бөөний худалдааны сүлжээг барьж эхлүүлэх ажлыг Гадаад Харилцааны яам, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн Газар хоорондын Байнгын Зөвлөлдөх ажлын хэсгийн 4 дүгээр хуралдаанаар гаргасан ажлын төлөвлөгөөнд тусгаж БХБСайд, БХТөвийн дэд захирал холбогдох мэргэжилтнүүдийн хамт барилгын материалын лабораториудтай танилцаж, туршлага солилцох, мэргэжилтэн дадлагажуулах ажлыг хамтран зохион байгуулсан.Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор "Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ыг батлуулсан. Уг бодлогыг хэрэгжүүлэх арга	70%

					хэмжээний төлөвлөгөө БХБСайдын 2019 оны 67 дугаар тушаалаар батлагдсан. Энэхүү арга хэмжээний төлөвлөгөөний 5.5.1-д “Замын-Үүд, Алтанбулагийн чөлөөт бүсэд барилгын материалын ханган нийлүүлэлтийн сүлжээ байгуулна.” гэж тусгасан. Мөн тус төслийн ТЭЗҮ-ийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2050”-д тусгахаар Үндэсний хөгжлийн газарт санал хүргүүлсэн. Барилгын материалын бөөний хангамжийн сүлжээг Замын-Үүд чөлөөт бүс, Налайхын БМҮТП-тай уялдуулан хөгжүүлэх концепци гаргаж, энэ талаар НЗДТГ-ын Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар, Налайхын паркийн захиргаатай уулзалт зохион байгуулахаар тохирсон. Хавсралт : 2 файл	
7	2.31.Малчдыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх арга хэмжээ авна.	1. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон байр, дэд бүтэц, ахуйн нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах, орон сууцны хөтөлбөрт хамруулах	2017 - 2020	Орон сууцны хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн тоог жил бүр 50-аар нэмэгдүүлэх	"150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийн төслийг Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрт малчдын орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний нүүдэлчин ахуй нөхцөлд тохирсон, байгаль орчинд ээлтэй, ус, дулаан, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцтай болоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авч хэрэгжүүлэхээр тусгасан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг БХБС-ын 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 125 дугаар тушаалаар батлуулж, холбогдох байгууллагуудад яамны 2019.07.16-ны өдрийн 03/2786 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар яамны 2019.09.18-ны өдрийн 01/3550 тоот албан бичгээр холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлсэн. Хавсралт : 2 файл	100%
8	2.36.Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, төлөв байдлыг тогтоох, хянах, сэргээн сайжруулах,	1. Бэлчээрийн харилцааг зохицуулах Бэлчээр хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах	2017 - 2020	Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх	ХХААХҮЯ-аас боловсруулан ирүүлсэн Бэлчээр хамгаалах хуулийн төслийн талаар ХХААХҮЯ-ны холбогдох албан тушаалтантай 2 удаа уулзалт зохион байгуулсан. Хууль зүй дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу Бэлчээр хамгаалах тухай хууль дангаараа байх шаардлагагүй, Газрын тухай хуульд нэг бүлэг болгон оруулахаар тохирсоны дагуу Газрын тухай хуульд нэг бүлэг болгон оруулах ажлыг гүйцэтгэж байна. Тус ажлын үндсэн хэрэгжүүлэгч нь ХХААХҮЯ болно. Хавсралт : 1 файл	100%
9	доройтол, талхагдал, цөлжилтийг бууруулах,	2. Бэлчээрийн газар зохион байгуулалтын тогтолцоог	2017 - 2020	Баруун бүсийн аймгуудын талхлагдсан бэлчээрийг	Тус яам ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ, Бодлого судлалын төв, “Ногоон алт төсөл”-ийн багтай хамтран ажиллаж байна. Бэлчээрийн хууль, Газрын тухай хуулийг уялдуулан боловсруулах асуудлаар БХБЯ, ХХААХҮЯ ,ГЗБГЗЗГ, Ногоон алт төсөл хамтран 2018.09.21-ний өдөр	100%

	бэлчээрт хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэхэд малчдын оролцоог нэмэгдүүлж, байгаль орчинд халгүй, дэвшилтэт аргыг ашиглана.	боловсронгуй болгох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах			нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх	уулзалт зохион байгуулсан. Мөн Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах явцад бэлчээрийн газрын асуудлаар ХХААХҮЯ-ны албан хаагчдад танилцуулга зохион байгуулсан. Тус ажлын үндсэн хэрэгжүүлэгч нь ХХААХҮЯ болно. Хавсралт : 1 файл	
10		3. Байгаль, экологийн онцлогтой уялдуулан бэлчээрийн газарт бүсчлэл тогтоож, бүс тус бүрийн төлөв байдлыг үнэлэх, хянах ажлыг зохион байгуулах	2017 - 2020		Зүүн бүсийн аймгуудын бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг хийх	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага буюу ХХААХҮЯ-наас Бэлчээр хамгаалах хуулийн төсөлтэй уялдуулан холбогдон гарах дүрэм, журмын хүрээнд бэлчээрийн газарт бүсчлэл тогтоох асуудлыг хэлэлцсэн. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан санал өгсөн болно. Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар"-ыг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн 34 дүгээр тушаалаар баталсан. Тус ажлын үндсэн хэрэгжүүлэгч нь ХХААХҮЯ болно. /хавсралт-1 файл/ Хавсралт : 1 файл	100%
11		4. Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний нөөц бэлчээрийг шинээр бий болгох, ашиглалтыг сайжруулах	2017 - 2020		Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээрийг 50.0 мян.га-аар нэмэгдүүлэх	Газрын тухай хуульд заасны дагуу аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газруудыг судалж, тусгай хэрэгцээнд авсан газруудын газар ашиглалтыг сайжруулах журмын төсөлд санал өгч, мөн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголд ХХААХҮЯ-наас холбогдох саналыг ирүүлсэн болно. Тус ажлын үндсэн хэрэгжүүлэгч нь ХХААХҮЯ болно. Хавсралт : 1 файл	100%
12	2.48.Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох	6. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг боловсруулан батлуулах	2017 - 2020		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор "Үйлдвэржилт 21:100" /2018-2021 он/ хөтөлбөр батлагдсан, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан асуудлаар хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт : 1 файл	100%
13	экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд	7. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр	2017 - 2020		Үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлж,	Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн	100%

	<p>үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.</p>	<p>төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах</p>		<p>туршилт тохируулга хийгдэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын 45-60 хувь нь хийгдэх</p>	<p>бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд 21 аймагт бетон зуурмаг, элс хайрга, цонх хаалга, тоосго, хөнгөн блок, цементийн үйлдвэрүүд байгуулагдаж байна. Баян-Өлгий аймагт цементийн үйлдвэр, тоосгоны үйлдвэр, Говь-Алтай аймагт бетон зуурмаг, карьерийн үйлдвэр, Завхан аймагт цонх хаалганы үйлдвэр, карьерийн үйлдвэр, Баянхонгор аймагт хөнгөн бетоны үйлдвэр, Сүхбаатар аймагт бетон зуурмаг, Дорнод аймагт хөнгөн бетоны үйлдвэр, Увс аймагт бетон хийцийн үйлдвэрүүд тус тус ашиглалтанд ороод байна. Улаанбаатар хотод 2019 онд шинээр байгуулагдсан үйлдвэрүүдээс доорх үйлдвэрүүд импортыг орлосон бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлээд байна. Үүнд: “Лидер комплекс коннект” ХХК-ийн сантехникийн хуванцар хоолой, холбох хэрэгслийн үйлдвэр байгуулагдаж МҮ-009/19 тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, “Бурхант Хясаат” ХХК-ийн Полиуретан шүршдэг болон цутгадаг хөөс, скорлуп, гулдмайн үйлдвэр байгуулагдаж МҮ45-065/19 тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, “Гэрэлт дөл констракшн” ХХК-ийн авагддаггүй хэв хашмалын үйлдвэр байгуулагдаж МҮ-123-066/19 тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, “ГБЗЛ” ХХК-ийн Даацын металл хийц, бүтээцийн үйлдвэр байгуулагдаж МҮ-050/19 тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, “Бэст Эргэл” ХХК-ийн бетоны химийн нэмэлтийн үйлдвэр МҮ-019/19 тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан нь импортыг орлох үйлдвэрүүд байна. Барилгын материалын 39 үйлдвэр нийслэл болон орон нутагт шинээр байгуулагдаж, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.</p>	
14		<p>16. Монголд үйлдвэрлэсэн цементийг экспортлох бизнесийн таатай орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах</p>	2017 - 2020	<p>Монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг экспортлох хууль, эрх зүйн орчинтой уялдуулан цемент экспортлох эрх зүйн</p>	<p>Монгол экспорт хөтөлбөрийн хүрээнд Монголд үйлдвэрлэсэн цементийг экспортлох бизнесийн таатай орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд цемент экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг бодлогоор дэмжин ажиллаж байна. Монголд үйлдвэрлэсэн цементийг экспортлох ажлын хүрээнд БХБСайд Х.Баделхан дотоодын цемент үйлдвэрлэгчдийн удирдлагуудыг хүлээн авч санал хүсэлтийг сонслоо. Үйлдвэрийн удирдлагуудийн хүсэлтээр Монгол Улс болон ОХУ-ын ЗГ хоорондын хуралдаанд санал хүргүүлэхээр ГХЯ-нд 2019 оны 05 сарын 09-ний өдрийн 01/1664 тоот албан бичгээр санал хүргүүлсэний дагуу Улаанбаатар хотод 2019 оны 04 сарын 28-30-ний хооронд зохион байгуулагдсан Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хуралдаанд санал оруулан хэлэлцүүлсэн. Мөн цементийн Евро стандартыг орчуулан нутагшуулах шаардлагатай болсон тул цемент үйлдвэрлэгч нартай</p>	100%

					орчныг бүрдүүлэх	хамтран ШУТИС-ийн багш нарын багийг ажиллуулж, цементийн турших аргын багц стандартыг боловсруулан Бетоны стандартын техникийн хорооны 3 удаагийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Евро стандартуудыг “МАК” ХХК-ийн дэмжлэгтэйгээр орчуулан үндэсний стандарт болгохоор Стандарчлал хэмжил зүйн техникийн хорооны хурлаар хэлцүүлэн дэмжигдсэн. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын турших аргын химийн шинжилгээний стандартуудыг шинээр боловсруулан Бетоны стандартын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Хятадын Стандартын байгууллага, СХЗГ-тай хамтран 2019 оны 12 дугаар сарын 2-4-ний хооронд холбогдох үйлдвэр, лаборатори, итгэмжлэлийн байгууллагуудад сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан. Хавсралт : 1 файл	
15	2.72.Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	6. Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах	2017 - 2020	73,8 тэрбум төгрөг - Хөгжлийн банк 800,0 сая төгрөг - Хувийн хэвшил		Монгол Улсын Засгийн газрын 2018.03.14-ний өдрийн 72, 04 дүгээр сарын 25-ний 106, 05 дугаар сарын 134 дүгээр тогтоолуудаар гадаадаас ажиллах хүчин оруулах асуудлыг шийдвэрлүүлсэн. Барилгын салбарт ажиллах хүчнийг нэмэгдүүлсэнээр дотоодын ган туйвангийн 10 үйлдвэр 54000 тонн ган туйван үйлдвэрлэсэн. Тухайлбал: Хятадын хөрөнгө оруулалттай “Дөл түшиг” ХХК нь үйлдвэртээ технологийн шинэчлэл хийж 6500 тонн ган туйван үйлдвэрлэж зах зээлд нийлүүлсэн. Дарханы төмөрлөгийн үйлдвэр 2018 онд 4210 тонн ган туйван үйлдвэрлэж, 1 тонн ган туйванг 1.840,0 мянган төгрөгөөр борлуулалт хийсэн. Өмнөх онтой харьцуулахад ган туйвангийн импорт 15%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэний үр дүн юм. 2019 онд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй барилгын ган туйвангийн 16 үйлдвэрээс 12 үйлдвэр хэвийн ажиллаж, 2018 онд 36 000 тонн ган туйван үйлдвэрлэж байсан бол 2019 онд 55700 тонныг үйлдвэрлэсэн. Энэ нь үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 54 хувиар өссөнийг харуулж байна. Энэ нь 2019 онд “Лэл минерал” ХХК, “Дархан анд” ХХК-ын ган туйвангийн үйлдвэр шинээр ашиглалтад орсонтой холбоотой. Дотоодын гангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Бэрэн группын гангийн үйлдвэрийг бодлогоор дэмжин хөнгөлөлттэй зээлд хамруулсан. “Бэрэн” ХХК-ийн гангийн үйлдвэрт 73,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас олгосон. Энэхүү санхүүжилтээр домен 35 м.куб зуух, домен 70 м.куб зуух, кран, хүчилтөрөгчийн конвертор, цахилгаан нуман зуух, шанаган зуух, тасралтгүй цутгах машин, хөргөлтийн усан сан, хүчилтөрөгчийн	100%



					станц, цувих цехийг ашиглалтад оруулаад байна. Нийт ажлын гүйцэтгэл 80%-тай байна. Хавсралт : 3 файл	
16	2.76.Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Орон сууцны ипотекийн зээлийн хэрэгжилт, өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, ипотекийн зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлогын хүрээнд зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах	2016 - 2017	274.5 тэрбум төгрөг	Орон сууцны ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд УИХ-ын ЭЗБХ-ны 2018 оны 35 дугаар тогтоолыг боловсруулж, ЗГ-т дараах чиглэлийг өгсөн. Үүнд: - Засгийн газраас банкуудад олгох ипотекийн зээлийн эх үүсвэрийн хүүг 1% хүртэл бууруулах, банкуудын өөрийн эх үүсвэрийг татан оролцуулах, зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх. - Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гэрээнд өөрчлөлт оруулахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, СЗХ-нд чиглэл болгосон. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор "Орон сууцны санхүүжилтийн журам"-ыг батлуулж, ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг 1% болгон бууруулж арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулах үүрэг болгосны дагуу Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 6/2019/38/0519/104 тоот гурвалсан гэрээг байгуулсан. Үүний дүнд 2019 оны жилийн эцсийн байдлаар Монголбанкнаас 213.4 тэрбум төгрөг, улсын төсвөөс 112.0 тэрбум төгрөг, Арилжааны банкуудын эх үүсвэрээс 117.9 тэрбум төгрөг буюу нийт 443.3 тэрбум төгрөгийг ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй зээлд зарцуулж, 6476 зээлдэгчийг хамруулсан. Энэ нь 2018 онд олгосон ипотекийн зээлтэй харьцуулахад 138.7 тэрбум төгрөг, 1800 зээлдэгчээр их байна. Хавсралт : 1 файл	100%
17	2.77.Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, "Хямд өртөгтэй орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1. "Орон сууц" үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2016 - 2020	-	"150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 202 дугаар тогтоолоор батлуулсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БХБС-ын 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 125 дугаар тушаалаар батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг 2019.09.18-ны өдрийн 01/3550 тоот албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн судалгааг аймаг, орон нутгаас гаргуулан авч нэгтгэн боловсруулж, гарын авлага болгон хэвлүүлэхээр бэлтгэж байна. Хавсралт : 2 файл	100%
18		2. "Ногоон хувийн орон сууц" загвар төслийг үе шаттай эхлүүлэх	2017 - 2020	117,2 сая төгрөг –	Загвар төслийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгын ажлын зураг төсөл боловсруулах 2019.01.09-ний өдрийн 2019/01 тоот ажлын даалгаврыг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Төслийн архитектур төлөвлөлтийн даалгавар,	100%

				НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр	<p>техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авсан. Уг төслийн шилдэг зураг төсөл шалгаруулах уралдааныг нээлттэй зарлаж, шалгарсан “Эн Эс Партнерс” ХХК-тай 2019.04.26-ны өдөр НАМА/CD003-19 тоот гэрээг байгуулж, ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгч гэрээт хугацаанд 80 айлын ногоон сууцны хотхоны зураг төслийг боловсруулж, 2019.11.22-ны өдөр тус яаманд хүлээлгэн өгсөн. Цаашид гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулахад урьдчилсан байдлаар шаардлагатай 117,2 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр яамны 2019.12.09-ний өдрийн 03/4587 тоот албан бичгийг НҮБХХ-т хүргүүлж шийдвэрлүүлээд байна.</p> <p>Хавсралт : 3 файл</p>	
19		3. Аймаг бүрт "1000 айлын орон сууц" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2016 - 2020		<p>Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айл, нийт 1542 айлын орон сууцыг 2019 оны 6 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар тогтоолоор Монгол Улсын ХБ-аас орон нутгийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн. Тэдгээр орон сууцнуудад Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар баталсан “Түрээсийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах журам”-ын дагуу тухайн орон нутагт амьдарч байгаа иргэдийг хамруулах ажлыг орон нутгаас зохион байгуулсан. Аймаг бүрт 1000 айлын орон сууц барих зорилтын хүрээнд "150 мянган айлын орон сууц" хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрт аймгуудын төвд амьдарч байгаа 194,307 өрхийн 58,838 өрх нь нийтийн болон амины орон сууцанд, 135,469 өрх нь гэр, гэр хорооллын байшинд амьдарч байгаагаас гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 50,0 мянган өрх, шинэ суурьшил, дагуул, хаяа хот, тосгодыг хөгжүүлэх хүрээнд 20,0 мянган айлын орон сууц барихаар төлөвлөн ажиллаж байна. Хавсралт : 1 файл</p>	100%
20		4. Нийслэлд 1000 айлын түр орон сууцыг барьж ашиглалтад оруулах	2017 - 2020	283,0 сая төг	<p>2019 онд “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт БХБЯ-ын Төрийн нарийн бичгийн дарга, БНХАУ-ын Буцалтгүй тусламжийн албаны дарга нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Зураг төслийг “Интеллект тауер” ХХК боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр БХБЯ-нд хүлээлгэн өгсөн. Батлагдсан зураг төслийн дагуу нийт 132.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр тусгагдсан. Орон сууцны хорооллын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, мэдээлэл холбооны</p>	100%

					техникийн нөхцлүүдийг холбогдох газруудаас авч, шугам сүлжээний зураг төслийг боловсруулан, хянуулан батлуулсан. Төслийн ТЭЗҮ, ажлын иж бүрэн зураг төсөл, төсвийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн ажлын алба болон Төслийн менежментийн компанитай хэлэлцэж, тохиролцож, 2019 оны 11 дүгээр сард эцэслэн хүлээлгэн өгсөн. Барилга угсралтын ажлыг 2020 оны 2 дугаар улиралд эхлүүлнэ. Хавсралт : 1 файл	
21	2.78.Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлнэ.	1. Барилга байгууламжийн норм, нормативын ерөнхий баримт бичгийн ерөнхий тогтолцоог шинэчлэн боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангуулах	2016 - 2018	32.1 сая төг	Барилгын тухай хууль”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-г боловсронгуй болгох ажлын техникийн даалгаврыг боловсруулж, 2017.09.07-ны өдөр батлуулан "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-тай хамтарч 2017.12.05-ны өдрөөс боловсруулалтыг эхлүүлсэн. Тогтолцооны эхний төслийг ОХУ, АНУ, ЕХ-ны баримт бичигтэй харьцуулсан судалгаа хийж, яамны газар хэлтсийн дарга, хуулийн хэлтсийн мэргэжилтнүүдтэй 2 удаа хэлэлцэн өгсөн үүрэг чиглэлийн дагуу боловсруулж тус яамны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар 2018.02.23-ны өдөр хэлэлцэж, дэмжигдсэн. Мөн 2019.02.01-ний БХБ-ын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дэмжсэн. Засгийн газрын гишүүд, төрийн бус байгууллагуудаас санал авч тусган ЗГХЭГ-т 2019.03.05-ны өдрийн 01/774 албан тоотоор хүргүүлсэн. Төслийг Засгийн Газрын 2019.03.21-ний хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн бөгөөд Засгийн газрын 106 дугаар тогтоолоор батлуулаад байна. Энэхүү баримт бичигт техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичигт тавигдах шаардлага, бүтэц агуулга, боловсруулж батлуулах дараалал үйл ажиллагааны талаарх зохицуулалтуудыг тусгасан. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцооны хэрэгжилтийг хангах зорилгоор шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа баримт бичгүүдийн боловсруулалтанд хяналт тавьж удирдлага зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Хавсралт : 2 файл	100%
22		2. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах,	2016 - 2020	1.628.6 сая төг	Барилгын хөгжлийн төвийн Норм, нормативын хэлтэс “Барилга байгууламжийн норм, нормативын сан”-гийн хөрөнгөөр 2019 онд: - Техникийн зохицуулалт - 3ш - Барилгын норм ба дүрэм - 32ш - Барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал - 53ш - Стандарт - 22ш - Нэмэлт санхүүжилт шийдвэрлэх - 5ш - Сангийн журмын хүрээнд зарцуулах зардал - 5ш - Бусад хүрээнд төлөвлөгдсөн ажил - 9ш. Нийт 129 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж	100%

		мөрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх				ажиллаа. Үүнээс шинээр тусгагдсан 33 ажил, үргэлжлэн хийгдэх 96 ажил байна. Ажил тус бүрийн боловсруулалтын явц жилийн эцсийн байдлаар дараах байдалтай байна. 1.Барилга, хот байгуулалтын сайд, холбогдох байгууллагын тушаал шийдвэрийн дагуу батлагдаж 100 хувийг гүйцэтгэлтэй - 58 ажил. 2.Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлж, өгсөн санал зөвлөмжүүдийг тусгаж батлагдах шатанд 90 хувийн гүйцэтгэлтэй - 13 ажил, 3.Холбогдох мэргэжлийн орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, өгсөн санал зөвлөмжүүдийг тусган ажиллаж 80 хувийн гүйцэтгэлтэй - 7 ажил, 4.Төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, редакц шүүмж томилон засвар өөрчлөлтүүдийг оруулж байгаа 70 хувийн гүйцэтгэлтэй - 15 ажил, 5. Норм, нормативын эхний төслийг хүлээн авч хянан үзэх, үнэлгээ хийж байгаа 60 хувийн гүйцэтгэлтэй 6 ажил, 6.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж норм боловсруулах ажлыг эхлүүлсэн/-7 ажил, /50%-ийн хэрэгжилттэй/ 7.Техникийн даалгавар хянан батлуулсан - 8 ажил, /40%-ийн хэрэгжилттэй/ 8.Холбогдох судалгаанд үндэслэн Техникийн даалгаврыг боловсруулсан - 2 ажил, /30%-ийн хэрэгжилттэй/ Нийт ажлын явцын дундаж хувь - 85,8%-тай байна. Хавсралт : 1 файл	
23		3. Шингэрүүлсэн хийн түлш, сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах болон ногоон барилгын чиглэлээр төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай норм, дүрэм, стандартыг боловсруулах, батлах	2017 - 2020	40.0 сая төг	Барилга, байгууламжийн норм нормативын сангийн 2018, 2019 оны төлөвлөгөөний дагуу дараах хий хангамж, эрчим хүчний хэмнэлт, ногоон барилгын төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах норм, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: “Хийн хангамж” /БНБД 42-01-04/2008/ барилгын норм дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулан МХЕГ, ОБЕГ-аас санал авч тусган Барилга, хот байгуулалтын сайдын 2019.05.29-ний 98 дугаар тушаалаар батлуулсан. “Барилгын дулаан хамгаалалт” /БНБД 23-02-09/ барилгын норм, дүрмийг Европын холбоо, олон улсын жишиг болон үндэсний онцлогт нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна. НҮБХХ-ийн Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ /НАМА/ төслийн хүрээнд “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тооцох аргачлал”, “Барилгаас ялгарах хүлэмжийн хийг тоолох, бүртгэх, мэдээлэх журам”, “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээг тооцох аргачлал” /БД 25-101-19/, “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг бүртгэх журам”-ыг боловсруулж батлуулахаар ажиллаж байна. Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг шинээр боловсруулах ажлын хүрээнд АХБ-ны дэмжлэгээр Булган аймгийн төвийн хэсэгчилсэн ерөнхий	70%	

					<p>төлөвлөгөөны ногоон хот байгуулалтын загвар төсөл байхаар боловруулна. Мөн ногоон барилгын чиглэлээр "Олон улсын санхүүгийн корпораци" ОУБ /IFC/, "Даян дэлхийн ногоон хөгжлийн сан" ОУБ /GGGI/, Германы хамтын ажиллагааны байгууллага "GIZ"-нартай хамтран ажиллаж байгаа ба БОАЖЯ-тай хамтарч эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын зураг төслийг хамтран боловсруулж байгаа бөгөөд энэхүү орон сууцыг барихад жилийн 8 хувийн хүүтэй зээл олгодог байхаар ЗГ-аар шийдвэрлүүлээд байна. Мөн АХБ, НЗДТГ-тай хамтарч Дэнжийн 1000, Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа дэд төвүүдэд орлогод нийцсэн орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ногоон орон сууцны барилга баригдсан нөхцөлд хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжуудыг АХБ-наас олгохоор тохирсон.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	
24	<p>2.79.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна.</p>	<p>1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажлын хүрээнд Хот байгуулалт, эрдэм шинжилгээний зураг төслийн институтийг байгуулж, суурь судалгааны ажлыг гүйцэтгэх</p>	2016 - 2019	600,0 сая төг	<p>"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах зөвлөх үйлчилгээний 119 тоот гэрээг 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-тай байгуулан, төслийн судалгааны ажил болон төсөл боловсруулах ажлыг 2019 онд улсын төсвийн 600,0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлж байна. Төслийг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг 21 аймгийн Засаг даргын захирамжаар аймаг тус бүрт байгуулан ажиллуулсан. Судалгааны ажлын хүрээнд хангайн бүсээс бусад төвийн бүсийн 7, зүүн бүсийн 3, баруун бүсийн 5 аймгийн 160 сум, суурин газар, тосгонд ажиллаж, 15 аймгийн төвд төслөө танилцуулж, холбогдох саналыг авсан. Мөн сум, суурин газар бүрт орон нутгийн удирдлагыг хамруулсан фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулж, 34 судалгааны маягтаар нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тоон мэдээллүүдийг гаргуулан авч нэгтгэн боловсруулсан. Тухайн сум, суурин газар бүрт холбогдох барилга, байгууламж, хот байгуулалтын дэд бүтцийн талаар фото зураг аван бичлэг хийж, ажиглалтын болон баримтжуулах судалгааг Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 70 хувьд хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хавсралт : 3 файл</p>	100%
25		<p>2. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг</p>	2016 - 2019		<p>БХБС-ын 2019.02.19-ний өдрийн 31 дүгээр тушаалаар Зөвлөх багийг байгуулан ажиллуулж, "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл" боловсруулах ажлыг мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр ханган, хамтран ажиллаж байна. Төсөл боловсруулах ажлын явц, үр дүнг хянах, нэгдсэн удирдамж,</p>	100%

		боловсруулж, батлуулах			чиглэлээр хангах үүрэг бүхий Төслийн хамтарсан зохицуулах хороог Ерөнхий сайдын 2019.03.21-ний өдрийн 32 дугаар захирамжаар байгуулсан. Төслийн хүрээнд салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах үүрэг бүхий 5 дэд ажлын хэсгийг БХБС-ын 2019.06.11-ний өдрийн 110 дугаар тушаалаар, төслийн хүрээнд боловсруулах бодлогын баримт бичгүүдийн харилцан уялдаа, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах, зөвлөх багуудтай хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг БХБС-ын 2019 оны 158 дугаар тушаалаар тус тус байгуулан ажиллаж байна. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын техник туслалцааны хүрээнд “Хүн амын нутагшилт, суурьшлыг хөгжлийн төсөл” боловсруулахад олон улсын туршлага, бодлогын дэмжлэг үзүүлэх, зөвлөмжийг боловсруулахаар 2019 оны 01 дүгээр сараас хамтран ажиллаж байна. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг эхний байдлаар боловсруулсан “Дунд шатны тайлан 1”-ийн хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, салбарын мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачдыг хамруулан зохион байгуулж, холбогдох яам, газруудаас санал авч, төсөлд тусгаад байна. 2020 оны улсын төсөвт 2,8 тэрбум төгрөгийг тусган батлуулсан бөгөөд 2020 онд төслийн судалгааны ажлыг бүрэн хэрэгжүүлж дуусгана. Хавсралт : 5 файл	
26		3. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлан, хэрэгжилтийг зохион байгуулах	2019 - 2020		“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын санхүүжилтийн эх үүсвэр нь 2017 онд батлагдаагүй Монгол Улсын 2018, 2019 оны Төсвийн тухай хуульд 600 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ч хөрөнгийн асуудал хугацаа хоцорч шийдвэрлэгдсэнээс шалтгаалан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах хугацаа хойшлогдсон. Иймд төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажил хойшлогдож байгаа болно.	Үнэлэх боломжгүй
27	2.80.Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн	1. Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах	2016 - 2018		Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг төслийг боловсруулж, 2019.04.30-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан Геодези, зураг зүйн удирдах ажилтны 2 дугаар зөвлөгөөнөөр хэлэлцүүлсэн. Тус зөвлөгөөнөөс гарсан саналыг тусган, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2019.05.24-ний өдрийн 01/1034 тоот албан бичгээр ирүүлсэн. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор	70%

	<p>зохицуулалтыг боловсронгуй болгоно.</p>				<p>батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-д 2018 оны 294 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу уг төслийн холбогдох үнэлгээнүүдийг боловсруулах ажлыг зохион байгуулсан. Төрөөс Газрын харилцааны талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл, Төрөөс Геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслүүдийг эцэслэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Хавсралт : 4 файл</p>	
28		<p>2. Газрын тухай, Газрын кадастрын тухай, Газрын үнэлгээ, төлбөрийн тухай, Геодези, зураг зүйн тухай хуулиудын эрх зүйн шинэтгэлийг хийх</p>	2016 - 2019		<p>БХБСайдын 2019 оны 33 дугаар тушаалаар Газрын тухай багц хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Улсын бүртгэлийн багц хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2018 оны 54 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Газрын сангийн нэгдмэл удирдлагыг Газрын тухай хуулийн төсөлд тусгах талаарх нийтийн эрх зүйн судалгаа, Иргэний хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлэн газрын эрхийн төрлийг Газрын тухай хуулийн төсөлд томъёолох талаарх иргэний эрх зүйн судалгааг гэрээгээр гүйцэтгүүлэн хүлээн авсан. Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын дагуу хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг, хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны ажлын тайлангийн хамт боловсруулж, 2019.03.15, 2019.05.03-ны өдөр хуулийн хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан тайлангийн хамт боловсруулж, 2019.04.05-ны өдрийн 01/1179 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлж, хуулийн үзэл баримтлалыг 2019.05.01-ний өдөр батлуулсан. Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг БХБСайд, Сангийн сайд, ХЗДХСайд нар хамтран батлуулахаар 2019 оны 01/1798 тоот албан бичгээр СЯ-нд хүргүүлээд байна. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, дагалдан батлагдсан аргачлалын дагуу боловсруулж 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.ЗГ-ын гишүүдээс 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/4440 тоот албан бичгээр санал авч боловсруулсан бөгөөд</p>	70%

					БХБСайдын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хавсралт : 4 файл	
29		3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016 - 2018		Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, өргөн барьсан ба УИХ-ын чуулганы 2018.04.26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлуулж, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийн хугацааг 10 жилээр сунгасан.	100%
30		4.Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан Газар чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016 - 2018		БХБ-ын сайдын 2019 оны 33 дугаар тушаалаар Газрын тухай багц хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын дагуу хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны ажлын тайлангийн хамт боловсруулсан. Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан тайлангийн хамт боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар 2019.04.05-ны өдрийн 01/1179 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. ХЗДХС-аас 2019 оны 06 дүгээр сарын 20-ний өдрийн 1-1/2956 тоотоор үзэл баримтлалыг буцаасан. Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хүрээнд хуулийн төслийг боловсруулаад явах тусдаа хууль байх шаардлагагүй гэсэн чиглэл өгсөн. Хавсралт : 2 файл	Үнэлэх боломжгүй
31		5. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016 - 2018		Тус хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, урьдчилан тандан судалгааны ажлын тайланг 2017.07.24-ний өдрийн БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хуулийн үзэл баримтлалын төслийг буцаах тухай 2018.07.25-ны 1-1/3772 тоот албан бичгийг ирүүлсэн тул хуулийн үзэл баримтлалын төсөл, тандан судалгааг дахин боловсруулж, ЗГХЭГ-ын дарга, ХЗДХЯ-ны саналыг тусган, хуулийн төслийн үзэл баримтлалыг ЗГХЭГ-ын дарга болон ХЗДХ-ийн сайд хамтран баталж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.17-ны	70%



					өдрийн 1-1/5595 тоот албан бичгээр ирүүлсэн. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо, холбогдох судалгааны хамт боловсруулж байна. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2019.05.30-ны өдөр, ажлын хэсгийн хурлыг 2019.05.31-ний өдөр тус тус зохион байгуулсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулан ГЗБГЗЗГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн болно. Хавсралт : 1 файл	
32		6. Улсын тусгай хэрэгцээний газарт хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, холбогдох дүрэм, журам, норм, стандартыг боловсронгуй болгох	2016 - 2018		"Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг Эрхлэх газарт 2017.09.21-ний өдрийн 01/2763 тоот албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2017.09.27-ны өдрийн хуралдаанаар журмын төслийг хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газрын 287 дугаар тогтоолоор баталсан. Хавсралт : 1 файл	100%
33		7. Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах	2016 - 2020		Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах ажлын хүрээнд "Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах" гэрээт ажлыг гүйцэтгүүлсэн. Дунд шатны тайланг 2019.04.04-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн. 21 аймаг, нийслэлийн 2000-2004, 2008-2010, 2016 оны бэлчээрийн, 2005, 2011-2012, 2016, 2017-2018 оны тариалангийн, 2004, 2012-2016, 2016, 2018 оны хот, суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тоон мэдээллийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэх ажлыг хийсэн. Газрыг зохистой ашиглаж, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах гэрээт ажлыг гүйцэтгүүлж, 400 орчим захиалгат хянан баталгааны ажлын тоон мэдээллийг авч нэгтгэн 5000 орчим мониторингийн сүлжээний цэг байгуулсан. Ажлын эцсийн шатны тайланг хүлээн авч 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн. /Нууц ажил тул file хавсаргах боломжгүй./	100%
34	2.81.Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах,	1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг тодотгох	2016 - 2018		Өвөрхангай аймгийн Арвайхээр, Тарагт сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/1770 тоот, "Баян-Өлгий аймгийн Өлгий, Бугат сумдын	100%

	шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.				хилийн цэсэд өөрчлөлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 1/1874 тоот албан бичгээр тус тус ХЗДХЯ-нд хүргүүлж батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01/3986 тоот албан бичгээр саналыг авч нэгтгэн Сангийн сайд, ХЗДХСайдаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авч ЗГХЭГазарт 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/4564 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 56 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэрийг гаргуулан УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/30, 01/31 тоот албан бичгийг Сангийн сайд, ХЗДХСайдад хүргүүлж холбогдох зөвшөөрлийг авч, 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн барьсан болно. Хавсралт : 1 файл	
35		2. Монгол Улс, ОХУ-ын хоорондох хилийн цэсийг тодотгож, баталгаажуулах ажлыг зохион байгуулах	2016 - 2020		Монгол Улс, ОХУ-ын хоорондох хилийг тодруулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг /2016 онд байгуулагдсан/ ГЗБГЗЗГ-т ажиллаж байна. Хилийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 15.3. дахь заалт болон Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.1.2.-т заасны дагуу Монгол Улс, ОХУ-ын хоорондох хилийн цэсийг тодотгож, баталгаажуулах ажил нь хоёр орны Засгийн газрын түвшинд зохион байгуулагдах ажил тул ГХЯ-ны холбогдох газар, ХХЕГазар болон ГЗБГЗЗГазрын хамтарсан шийдвэрийг үндэслэн Ажлын хэсэг байгуулагдах тул 2020 онд зохион байгууллахаар төлөвлөн ажиллаж байна. ОХУ-ын буцалтгүй тусламжаар МУ-ын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах асуудлыг ЗГ-ын 2019.04.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, уг асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлэн зөвлөмж авах нь зүйтэй гэж шийдвэрлэсний дагуу ЗГХЭГ-аас ҮАБЗ-д холбогдох материалыг хүргүүлсэн. ҮАБЗ-өөс дээрх ажлыг дотоодын хөрөнгө оруулалтаар хийх нь зүйтэй гэж зөвлөсний дагуу ОХУ-ын буцалтгүй тусламжийг авах боломжгүй болсон. 1:25000-ны масштабтай байр зүйн зураг зохиох суурь зураг болох сансрын зургийг 2018-2019 онд БНХАУ-ын Хэмжил, зураглалын байгууллагаас нийт нутаг дэвсгэрийн 70 хувьд хамрах талбайн хэмжээнд авсан. Илүү өндөр нарийвчлалын зураг авахаар Азербайджан улсын Азеркосмос байгууллагатай 2019 оны 11 дүгээр сард хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, 2020 онд	Үнэлэх боломжгүй

					хамтарсан судалгааны ажил хийхээр тохиролцсон. 2017, 2018, 2019, 2020 оны төсөвт шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Хавсралт : 3 файл	
36	3. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах	2016 - 2020	413,0 сая төг		Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 45 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын явц 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай дууссан. Үүнд: Ортофото болон өндрийн тоон загварын 548 хуудас 2011-01-101/2019-01 дугаартай, 160 хуудас байр зүйн зургийг 2011-01-101/2019-02 дугаартай дүгнэлтээр 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, 220 хуудас ортофото болон өндрийн тоон загвар, 19144.5 км2 талбайн агаар, сансрын зургийг 2011-01-101/2019-05 дугаартай дүгнэлтээр 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Архивын Мэдээллийн Төвд хүлээлгэн өгсөн. Манай орны нутаг дэвсгэрийн үлдсэн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын холбогдох тооцоо судалгаа хийгдэж, 2017 онд ТЭЗҮ батлагдсан. Энэхүү ажлын санхүүжилтийг 2018, 2019, 2020 оны улсын төсөвт тусгах санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч тусгагдаагүй. ҮХГ-аас боловсруулж буй МУ-ын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа - 2050” бодлогын баримт бичгийн төсөлд нийт нутаг дэвсгэрийг байр зүйн зургаар зурагжуулах саналыг тусгасан. ОХУ-ын буцалтгүй тусламжаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах асуудлыг ЗГ-ын 2019.04.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, уг асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлэн зөвлөмж авах нь зүйтэй гэж шийдвэрлэсний дагуу ЗГХЭГ-аас ҮАБЗ-д холбогдох материалыг хүргүүлсэн. ҮАБЗ-өөс дээрх ажлыг дотоодын хөрөнгө оруулалтаар хийх нь зүйтэй гэж зөвлөсний дагуу ОХУ-ын буцалтгүй тусламжийг авах боломжгүй болсон. 1:25000-ны масштабтай байр зүйн зураг зохиох суурь зураг болох сансрын зургийг 2018-2019 онд БНХАУ-ын Хэмжил, зураглалын байгууллагаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 70 хувьд хамрах талбайн хэмжээнд авсан. Илүү өндөр нарийвчлалын зураг авахаар Азербайджан улсын Азеркосмос байгууллагатай 2019 оны 11 дүгээр сард хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, 2020 онд хамтарсан судалгааны ажил хийхээр тохиролцсон. /Уг ажил нь нууцын зэрэглэлтэй тул тайлагнах боломжгүй./	100%
37	4. Монгол Улсын 63 сум, суурин газарт	2016 - 2020			Улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын судалгааг Оюу толгой ХХК,	100%

		GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станц байгуулах			Таван толгой ХК, Энержи ресурс ХХК, Геомастер ХХК, Гео Инструментс ХХК, Геосүрвэй ХХК, Инженер геодези ХХК, Монмэп ХХК, Эрдэнэт үйлдвэр, Одон орон геофизикийн хүрээлэн зэрэг байгууллагуудаас авч нэгтгэсэн. Судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд 13 байгууллагын 64 байнгын ажиллагаатай станц суурилуулсан байна. Эдгээр 64 станцын байршил, нэр, хүлээн авагчийн төрөл, антены төрөл, хариуцагч байгууллага, солбицлын тогтолцоо зэргийг судалгаанд тусгасан. GNSS-ийн байнгын ажиллагаатай станцуудын хэвийн ажиллагааг хангах, бодит агшны хэмжилтийг алдаагүй хийх, станцуудын өгөгдлийг дамжуулах, хадгалах, архивлах асуудалд “Гео-инструментс” ХХК-тай хамтран ажиллаж, байнгын ажиллагаатай станцуудын удирдлагын “Trimble dynamic control” програм хангамжийг сүүлийн хувилбараар үнэ төлбөргүй шинэчлэн, байнгын ажиллагаатай станцуудын хэмжилтийн алдааг шалгаж, алдаагүй болгов. Мөн байнгын ажиллагаатай станцад доголдол гарсан тохиолдолд асуудал хариуцсан аймгийн болон агентлагийн мэргэжилтнүүдэд цахим шуудангаар мэдэгдэл очиж байх системийг хөгжүүлсэн. 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс Өмнөговь аймаг Ханбогд сум (OMA3), Цогтцэций сум (OMA2), Булган аймаг Тэшиг сум (BUA2), Дорноговь аймаг Замын-Үүд сум (DOG2), Дархан-Уул аймаг (drhn), Хөвсгөл аймаг Ханх сум (HUV2)-ын станцуудыг удирдлагын програмд холбож хэвийн ажиллагаанд оруулсан. GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын систем байгуулах төсвийг ГЗБГЗЗГазрын 2019 оны урсгал төсөвт суулгаж, ажлыг гүйцэтгэн, системийг 2019 оны 6-8 дугаар сард туршин, гэрээт ажлын үр дүнг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2019/14 дугаар дүгнэлтээр АМТ-д өгсөн. Шинээр байгуулах GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай суурин станцын холбогдох тооцоо судалгааг хийж, ТЭЗҮ-г 2018 онд батлуулсан. 2019, 2020 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Хавсралт : 3 файл	
38		5. Газар зүйн нэрийн тодруулалтыг улсын хэмжээнд хийх	2016 - 2018		Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг орон нутгийн төсөвт тусгуулах тухай ГЗБГЗЗГ-ын даргын 1/1118 тоотыг 2019.05.31-ний өдөр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэний дагуу Дундговь аймаг 2019 онд орон нутгийн төсвөөр Сайнцагаан, Өлзийт сумын 2700 орчим газар зүйн нэрийн тодруулалт, солбицолжуулалтын ажлыг гүйцэтгэсэн байна. Мөн Булган аймгийн 7 сум, Дундговь аймгийн 13 сумын нэрийн	70%

					<p>тодруулалтын Ажлын даалгаварыг хянаж, батлуулан, 2019 оны 12дугаар сард тухайн аймгуудад хүргүүлсэн. Өвөрхангай аймгийн 1 сумын газар зүйн нэрийн тодруулалтыг 2020 онд гүйцэтгэхээр санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган баталсан. Газар зүйн нэрийг зөв нэрлэж хэвшүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах үйл ажиллагааны хүрээнд “Газар зүйн нэр түүхийн түүчээ” TV нэвтрүүлэг бэлтгэн гаргаснаас гадна брошур бэлтгэж иргэдэд тараах, газар зүйн үнэн, зөв нэрийг хэрэглэх, хадгалах, хамгаалах талаар таниулан сурталчлах ажлыг 21 аймагт зохион байгуулсан. “Газар зүйн нэрийг тогтоох, хамгаалах, хадгалах, ашиглах” БНБД-ийн төслийг боловсруулж Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2019.10.31-ний өдрийн хурлаар, БХБЯ-ны Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн 2019.12.11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн стандарт боловсруулж 2019 оны 10 сард Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2019 оны 11 дүгээр сард Стандарт хэмжил зүйн газарт батлуулахаар хүргүүлсэн. Газар зүйн нэрийн тодруулалт, солбицолжуулалтын талаар танилцуулга бэлтгэн 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газрын ажилтнуудад танилцуулсан. 2020 оны төсөвт Газар зүйн 350 мянган нэрийн тодруулга, солбицолжуулалт хийх ажлын санхүүжилтийг тусгах санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Хавсралт : 1 файл</p>	
39		6. Өндрийн I ангийн сүлжээг шинээр байгуулах	2016 - 2018		<p>Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээний давтан хэмжилт буюу нивелирийн I ангийн (багц-1) нивелирдлэг хийх ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын “Геодези, байр зүйн зургийн мэдээллийн сан”-д баримт хүлээн авсан тухай 2017 оны 2017/ГБ33/75, 2017/ГБ33/79 тоот актууд, “Бэйс пойнт” ХХК-ийн 2017 оны 17/71, 17/72 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн “Геосет” ХХК-тай байгуулсан 2014.08.18-ны өдрийн 73 тоот гэрээт ажлыг 100 хувьтай гүйцэтгэсэн гэж дүгнэснийг хянан үзэж, ажлын гүйцэтгэлийн актыг үйлдэж, дүгнэсэн. Хавсралт : 1 файл</p>	100%
40		7. Өндрийн II ангийн сүлжээний давтан хэмжилт хийх	2016 - 2019		<p>Өндрийн 1-р ангийн сүлжээний цэгүүд дээрх GNSS-ийн сүлжээний нийт 375 цэгийн хэмжилтийн өгөгдлийг Архив, мэдээллийн төвөөс авч, засварлан тэгшитгэн бодолтыг хийж, урьд өмнө хийсэн ажлын үр дүнтэй харьцуулан шалгаж, солбицлын жагсаалт /каталог/-ыг</p>	Үнэлэх боломжгүй

					<p>геодезийн солбицол, тэгш өнцгийн солбицол, эллипсоидын өндөр, геоидын загвар ашиглан шилжүүлсэн ортометрийн өндөр гэсэн мэдээлэлтэйгээр бэлтгэсэн. Цэгүүдийн нормал өндрийг өндрийн 2-р ангийн цэгүүдтэй харьцангуйгаар тодорхойлж хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 1944 онд байгуулсан өндрийн 2-р ангийн сүлжээний 2 шугамын цэгийн мэдээллийг Орон зайн өгөгдлийн системд оруулахаар 2019 оны 06 дугаар сард хүлээлгэн өгсөн. 1944 оны өндрийн 2-р ангийн сүлжээний 104 цэгийн өндөр, өндөржилтийг 2018 оны өндрийн 1-р ангийн сүлжээний өндөр, өндөржилтийн харьцуулсан судалгааг гаргаж, танилцуулга бэлтгэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан. Өндрийн II дугаар ангийн сүлжээний давтан хэмжилт, хайгуул судалгаа, хэмжилт хийх ажлын холбогдох тооцоо судалгаа хийгдэж 2017 онд ТЭЗҮ батлагдсан. 2018, 2019 оны улсын төсөвт санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй, 2020 оны улсын төсөвт санал хүргүүлсэн боловч мөн тусгагдаагүй. 2020 онд Өндрийн II ангийн сүлжээний 140 цэг дээр 1-р ангийн нарийвчлалаар өндрийн сүлжээний хэмжилт хийх ажлыг ГЗБГЗЗГазрын урсгал төсөвт тусган батлуулсан. Хавсралт : 2 файл</p>	
41		8. Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах	2016 - 2018		<p>"Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах ажлыг хийхэд шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл 2017 онд баталсан. Энэ арга хэмжээнд шаардагдах төсвийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсвийн хөрөнгөөр 2018, 2019 онуудад санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад батлуулахаар саналыг хүргүүлсэн боловч (эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан) улсын төсөвт тусгагдаагүй хасагдсан болно. 2020 оны төсөвт тусгах саналыг хүргүүлсэн боловч мөн батлагдаагүй. Монгол Улсын геодезийн сүлжээний Эхлэл цэгийн төвийг Архангай аймгийн Эрдэнэбулган суманд суулгаж, тухайн цэгийн солбицлыг тодорхойлох хэмжилтийн ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь урсгал төсвөөс зохих хууль, тогтоож, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ хийн гүйцэтгүүлсэн. Уг ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 39 дүгээр хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллаж, тус аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт актаар хүлээлгэн өгсөн. Хавсралт : 1 файл</p>	Үнэлэх боломжгүй
42		9. Төрөөс орон зайн өгөгдлийн дэд	2016 - 2017		<p>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөл, бодлогын баримт бичгийн төслийн хэлэлцүүлгийг 2019.05.30, ажлын хэсгийн</p>	70%

		бүтцийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох			<p>хурлыг 2019.05.31-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-д 2018 оны 294 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу уг төслийн холбогдох судалгааг боловсруулж байна. Мөг тус ажлын хүрээнд "Нэгдсэн орон зайн мэдээллийн менежмент" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулахад хамтран ажилласан. Уг хэлэлцүүлэгт төрийн байгууллагуудын төлөөллүүд болон орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг хамруулан Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын хүрэх үр дүнг тодорхойлж, оролцсон оролцогчдоор гадаад болон дотоод орчны шинжилгээ хийлгэсэн. Тус хэлэлцүүлэг нь төрөөс орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах бодлогыг боловсруулахад судалгааны материал цуглуулах эхний алхам болов. Дэлхийн банкны Газар, орон зайн зөвлөх багтай хамтран Монгол Улсын Орон зайн мэдээллийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийн судалгааг 2019 оны 10 дугаар сарын 14-21, 11 дүгээр сарын 25-аас 12 дугаар сарын 04-нд хийж гүйцэтгэв. Судалгааны үр дүнг 12 дугаар сарын 04-ний өдөр төрийн байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулж санал солилцсон. Зөвлөх баг судалгааны үр дүнд үндэслэн хөрөнгө оруулалт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулан ажилласан. Хавсралт : 1 файл</p>	
43		10. Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх	2016 - 2018		<p>Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай болон 2020 оны төсвийн хязгаар, 2020 оны үндсэн чиглэлд тусгуулах санал өгсөн. 2020 оны төсөвт оруулж батлуулах ажлын хүрээнд уг ажилтай холбоотой судалгаа, танилцуулга, хууль, тогтоомж, ЗГҮАХХАХТөлөвлөгөө, ажлын даалгавар, техникийн төсөл зэргийг СЯ-нд хүргүүлсэн. Энэхүү арга хэмжээ нь 4 төрлийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэхээр тусгагдсан. 2019 онд уг арга хэмжээний хүрээнд дараах ажлууд зохион байгуулагдаж, хэрэгжсэн байна. Үүнд: 1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллийн системд оруулах газар зүйн нэрийн мэдээллийн сангийн загвар нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн даргын тушаалаар 2018 онд батлагдсан. Уг ажлын хүрээнд 2019 онд "Газар зүйн нэрийг тогтоох, хамгаалах, хадгалах, ашиглах" дүрмийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж, Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан. 2. Хаягийн цахим үйлчилгээ нэвтрүүлэх ажлын хүрээнд: Монгол Улсын ЗГ-ын 2013 оны 280</p>	70%

					дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулж Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан. Уг шинэчлэн батлагдсан журамд хаягийн иж бүрдлийг Нийслэл, аймаг, сумын хэмжээнд зааж өгсөн болно. "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг эрхлэх, нийтэд хүргэх" арга хэмжээг тусган батлуулахаар ажиллаж байна. 2020 оны Төсвийн тухай хуулиар 2020 онд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1,180,00 сая төгрөг батлагдсан. Хавсралт : 1 файл	
44	11. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх	2016 - 2020			Улсын хэмжээний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн стратегийг боловсруулж, техник хангамжийг шийдвэрлэх ажлыг хийхэд шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах 2017/15 тоот ажлын даалгаврыг 2017.05.31-ний өдөр батлуулж, батлагдсан ажлын даалгаврын дагуу техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, БХБ-ын дэд сайдаар батлуулсан. Тус арга хэмжээний шаардагдах төсвийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсвийн хөрөнгөөр 2017, 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад батлуулахаар саналыг хүргүүлсэн боловч (эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан) улсын төсөвт тусгагдаагүй тус тус хасагдсан болно. Энэ арга хэмжээний санхүүжилтийг 2019 оны төсвийн төсөлд 3.0 тэрбум төгрөгийг тусгуулахаар Сангийн яаманд 2018.08.15-ны өдрийн 01/3208 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч 2019 оны Төсвийн тухай хуульд тусгагдаагүй болно. 2020 оны Төсвийн тухай хуулийн XI.1.84-т Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэхэд зориулан 2.682.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгаад байна. Хавсралт : 1 файл	Үнэлэх боломжгүй
45	12. Газрын харилцааны иргэдэд үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах	2016-2020	-840.0 сая төг		"Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим систем байгуулах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр эцсийн шатны тайланг хүлээн авч акт үйлдэн санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг Газар	100%



					зохион байгуулалт геодези зураг зүйн газарт байгуулсан. /Нууц ажил тул fail хавсаргах боломжгүй./	
46		13. Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх	2016 - 2020	1,316 сая төг	Лэнд менежер програм хангамжийг нийслэл, 9 дүүргийн Газрын албаны кадастрын мэдээллийн санд нэвтрүүлэх, нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа ба “нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх” ажлыг зохион байгуулж ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. 2019 оны 12дугаар сарын 26-ны өдөр Эцсийн шатны тайланг хүлээн авч акт үйлдэн санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газарт Газрын кадастрын цахим системийг нэвтрүүлж иргэд онлайн аар мэдээллийг хүлээн авах боломжтой болсон. /Нууц ажил тул fail хавсаргах боломжгүй./	100%
47	2.82.Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016 - 2017		Хууль зүй дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар бүлэгт хот, суурины хот байгуулалтын бүсчлэл, газар ашиглалтын бүсчлэлийн суурь зохицуулалтыг нарийвчлан тусгасан. Хот байгуулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг ХЗДХ-ийн сайд, БХБ-ын сайдаар 2019.02.14-ний өдөр тус тус батлуулсан. Хуулийн төслийг БХБ-ын сайдын зөвлөлийн хурлаар 2019.10.22-ны өдөр хэлэлцүүлсэн. Зөвлөлийн гишүүдээс гарсан саналуудыг тусган хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4131 тоот албан бичгээр, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4132 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-ны 2019.12.16-ны өдрийн 6/8231, ХЗДХЯ-ны 2019.1216-ны өдрийн 1-1/5545 тоот албан бичгээр хүлээн авч, ЗГХЭГ-т 2019.12.17-ны өдрийн 01/4676 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. УИХ-аар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-аас 2019.12.30-ны өдрийн 6/8616, ХЗДХЯ-ны 1-1/5796 тоот албан бичгээр тус тус авч, ЗГХЭГ-аас 2019.12.31-ний өдөр УИХ-ын Тамгын газарт хуулийн төсөл өргөн барих тов тогтоолгох тухай албан бичгийг хүргүүлээд байна. Хавсралт : 1 файл	100%
48		2. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл	2016 - 2018		“Улаанбаатар хотын газар дээрх болон доорх инженерийн шугам сүлжээний зураглал хийх” ажлын хүрээнд яамтай байгуулсан	100%

		хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бүсчлэлийн төлөвлөлт, инженер геологи, газар хөдлөлтийн болон газар дээрх, доорх шугам сүлжээний зураглал хийж, мэдээллийн сан үүсгэн, мужлалын нарийвчилсан зураг төсөл боловсруулах			гэрээний дагуу нийслэлийн 9 дүүрэгт “Топсүрвэй”, “Геомастер”, “Эй Эс Эм” ХХК-ийн түншлэл газар дээрх болон доорхи инженерийн шугам сүлжээний зураглалын ажлыг бүрэн гүйцэтгэж, мөн “Инженер геодези” ХХК захиалагчийн техникийн хяналт хийж, 2017.08.23-ны өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд ажлын гүйцэтгэл 100% гэж дүгнэсэн. Мөн уг төслийн хүрээнд “Улаанбаатар хотын барилгажсан талбайн 1:5000, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн 1:10000 масштабтай газар хөдлөлийн бичил мужлалын зураг хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “ШУА-ийн Одон орон геофизикийн судалгааны төв” шалгарч, ажлыг бүрэн дуусгасан бөгөөд захиалагчийн зүгээс ГЗБГЗЗГ гэрээг дүгнэж, эцсийн тайланг хянаж, мэдээллийн санд оруулсан. Мөн ГЗБГЗЗГ-аас “Геоценоз”, “Бориг тэс” ХХК-уудын ирүүлсэн гүйцэтгэлд захиалагчийн хяналт хийж, 19 аймгийн геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран газар дээр нь тулгалт хийж, газар дээрх, доорх шугам сүлжээний зураглал бүрэн хийж дууссан. “Улаанбаатар хотын бүсчлэлийн төлөвлөлт, инженер-геологийн судалгаа, газар хөдлөлтийн болон газар дээрх, доорх зураглал хийж, мэдээллийн сан үүсгэх” /ХБГХ-2012-07/ төслийн хүрээнд нийт 5 багц ажлыг хийж дууссан бөгөөд захиалагчаас эцсийн тайланг хянаж, актаар хүлээн авсан. ГЗБГЗЗГ актаар хүлээж авсан дээрх 5 багц ажлыг мэдээллийн санд бүрэн оруулахад захиалагчийн зүгээс чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Хавсралт : 3 файл	
49	2.83.Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	1. УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах	2016 - 2020		“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг дүгнэх хот байгуулалтын үнэлгээ”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцийн Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлыг боловсруулж БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар 2019.11.22 -ний өдөр, БХБ-ын Сайдын зөвлөлийн хурлаар 2019.12.03-ны өдөр тус тус хэлэлцүүлж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт : 2 файл	100%
50		2. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл	2016 - 2020		2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган	100%

		хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг зохион байгуулах			ажилаж байна. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг дүгнэх хот байгуулалтын үнэлгээ”, “Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцийн Улаанбаатарын бүс, хот орчмын хот төлөвлөлтийн суурь судалгаа”-ны ажлуудыг нэгтгэн боловсруулж байна. Тус яам нь уг асуудлаар НЗДТГ, НХТЕТГ, НХТЭШХ-тэй хамтран ажиллаж байгаа бөгөөд холбогдох материалыг Архитектур, хот байгуулалтын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2019.05.02-ны өдөр хэлэлцүүлж саналыг авч тусгасан. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар 2019.05.13-ны өдөр хэлэлцүүлж, хурлаас гарсан саналуудыг судалгааны материалд тусгаж, НИТХ, БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар 2019.11.22 -ний өдөр, БХБ-ын Сайдын зөвлөлийн хурлаар 2019.12.03-ны өдөр тус тус хэлэлцүүлж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт : 2 файл	
51	2.84.Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг дахин нэмэгдүүлэх бодлого баримтална.	1. Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулах	2016 - 2017		Хот суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулан Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд Сайдын зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг дагуу Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нэгтгэсэн болно. Хот байгуулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулж ХЗДХ-ийн болон БХБ-ын сайдаар 2019.02.14-ний өдөр тус тус батлуулсан. Хуулийн төслийг БХБ-ын сайдын зөвлөлийн хурлаар 2019.10.22-ны өдөр хэлэлцүүлсэн. Зөвлөлийн гишүүдээс гарсан саналуудыг тусган хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4131 тоот албан бичгээр, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4132 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-ны 2019.12.16-ны өдрийн 6/8231, ХЗДХЯ-ны 2019.12.16-ны өдрийн 1-1/5545 тоот албан бичгээр хүлээн авч, ЗГХЭГ-т 2019.12.17-ны өдрийн 01/4676 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. УИХ-аар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-аас 2019.12.30-ны өдрийн 6/8616, ХЗДХЯ-ны 1-1/5796 тоот албан бичгээр тус тус авч, ЗГХЭГ-аас 2019.12.31-ний өдөр УИХ-ын Тамгын газарт хуулийн төсөл өргөн барих тов тогтоолгох тухай албан	100%

					бичгийг хүргүүлээд байна. Мөн УИХ-аар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-аас 2019.12.30-ны өдрийн 6/8616, ХЗДХЯ-ны 1-1/5796 тоот албан бичгээр тус тус авч, 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн барьсан болно. Хавсралт : 1 файл	
52	2.85.Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.	1. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	2016 - 2020		“Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”-ын төсөлд холбогдох нэмэлт, өөрчлөлт хийж, Барилга, хот байгуулалтын сайдын 2018.12.03-ны өдрийн 202 дугаар тушаалаар батлан, тус журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4169 дугаарт бүртгэсэн тухай ХЗДХЯ-наас 2019.01.18-ны өдрийн 1-1/ 311 тоот албан бичгээр мэдэгдсэн. Үүний дагуу “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”-ыг нийслэл, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Гэр хорооллын дэд бүтцийн газар болон холбогдох бусад газруудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2019.01.25-ны өдрийн 03/ 315 тоот бичгийг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2019.03.28-ны өдрийн 60 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хуулийг дагалдаж батлагдах дүрэм, журмын төслийг боловсруулж, батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүд “Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам”-ын төслийг 2 дэд ажлын хэсэгт хуваагдан эцэслэн боловсруулсан. 2019 оны 06 дугаар сард БХБЯ, ГЗБГЗЗГ, НГХДБГ-ын вэб хуудсанд журмын төслүүдийг байршуулан санал авсан. Мөн холбогдох яамд, газрууд, агентлаг, нийслэл, 21 аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-аас санал авах бичгийн дагуу ирүүлсэн саналыг товъёоглон тусгасан. Архитектур, хот байгуулалтын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2019.12.11-ний өдөр хэлэлцүүлж, дэмжигдсэн тухай зөвлөмж ирүүлсэн. Сайдын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. Ингэснээр Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журам, заавруудыг боловсруулж дуусаж байгаа бөгөөд батлагдсан журмуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт : 1 файл	100%
53		2. Хувийн хэвшилтэй хамтран “Хот байгуулалтын	2016 - 2020		Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.85.2-т тусгагдсан “Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Хот	100%

		форум”, “Газрын харилцаа, геодези, зураг зүйн форум”-ыг тогтмол зохион байгуулах			байгуулалтын форум”-ыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын сайдын 2019 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 126 дугаар тушаалаар байгуулсан. Хот байгуулалтын форум, хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Барилгын хөгжлийн төв дээр зохион байгуулсан. Уг арга хэмжээнд БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, НХБХГ, НГЗБА, МАЭ-ТББ, МБУА-ТББ-ын төлөөлөл 150 хүн оролцсон.	
54		3. Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох “ухаалаг” жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2017 - 2019		Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот /Аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2019.01.16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан. Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолын 2, 4 дэх заалт болон мөн оны 32 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, эх үүсвэрийг барьж байгуулах, уг хотыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажилд шаардагдах зардлын тооцоо, судалгаа хийх эхний ээлжинд шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг БОАЖ-ын сайд, БХБ-ын сайд нарт даалгасан. Үүний дагуу Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжийн арга хэмжээний хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах 602.6 сая төгрөгийн тооцооллыг хийж, “Хөрөнгө гаргах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2019.10.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 47 дугаар хуралдааны тэмдэглэл гарч, Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны 390 дүгээр тогтоолыг баталсан. Аэросити хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог БХБ-ын сайдын 2019.11.29-ний өдрийн А/152 тоот тушаалаар тушаалаар байгуулсан. Түүнчлэн "Аеро сити", "Майдар хот" байгуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр	100%

					хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хавсралт : 2 файл	
55	4. Аймгийн төв болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2017 - 2020	1,652 сая төг		Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн хэрэгжилтийн байдал, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний Улаанбаатар хотын бүс нутаг, хот орчмын судалгаа”-ны ажил, “Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепци”-ийг боловсруулж, Архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, НИТХурлаар 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, яамны ШУТТЗ-ийн хурлаар 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, БХБС-ын зөвлөлийн хуралдаанаар 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр тус тус хэлэлцүүлж, дэмжигдсэн. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны буудлыг даган бий болох шинэ хот “Аэросити” –ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор, Зуунмод хотын ХЕТ-г Засгийн газрын 2019 оны 30 дугаар тогтоолоор, Мандалговь, Сүхбаатар, Алтай, Улаангом, Цэцэрлэг, Арвайхээр хотын ХЕТ-г аймгийн ИТХ-ын тогтоолоор, Багануур хотын ХЕТ-г Засгийн газрын 2017 оны 347 дүгээр тогтоолоор, нийт 9 аймаг, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулаад байна. Орхон, Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай санхүүжилтийг 2018, 2019, 2020 оны улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд холбогдох санал хүргүүлсэн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй. Завхан аймгийн төв Улиастай хот, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж, мэргэжлийн зөвлөлийн гишүүдээс гарсан санал зөвлөмжийг тусгуулан холбогдох аймгуудын ИТХ-аар 2019 оны 12 дугаар сард хэлэлцүүлж дэмжигдсэн. Завхан аймгийн төв Улиастай хот, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг яамны ШУТТЗ-ийн хурлаар 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. БХБСайдын зөвлөлийн хуралдаанаар 2020 оны 01 дүгээр сард хэлэлцүүлнэ. Хавсралт : 5 файл	100%
56	5. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын	2016 - 2020			Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн зориулалттай орон сууцанд суурилуулсан ашиглалт, эдэлгээний хугацаа дууссан лифтийг “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн	100%

		шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх			зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай” хуулийн 16.6-д заасныг үндэслэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхээр судалгааны ажлыг хийж дуусгасан. Судалгааны ажил нь одоогийн байдлаар Улаанбаатар, Дархан-Уул, Эрдэнэт хотод хийгдсэн. Уг судалгааны хүрээнд МХЕГ, НЗДТГ, Нийтийн орон сууцны хөгжлийн сан, Сууц өмчлөгчдийн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн 273 хүртэлх ашиглалтын шаардлага хангахгүй лифт ашиглагдаж байгаа талаарх судалгааг гаргасан байна. Нийслэлийн 2019 оны төсөвт 1.1 тэрбум төгрөгийг 15 байрны лифтийг шинэчлэхээр, Улсын төсөвт 700 сая төгрөгийг тус тус тусгасан. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн А/110 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн худалдан авах ажиллагааны албанд эрх шилжиж очсон. Тус дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/146 дугаар захирамжаар үнэлгээний хорооны бүрэлдэхүүн байгуулагдаж нээлттэй тендер шадгаруулах журмын дагуу тендер зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээг “ОАКС экспресс монголиа” ХХК-тай 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр гэрээ байгуулж, 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр гэрээг дүгнэж дууссан байна. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/217 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн худалдан авах ажиллагааны албанд эрх шилжиж очсон. Захиалагчийн хяналтыг “Улаанбаатар лифт” НӨҮГ гүйцэтгэсэн байна. Улсын төсвийн хөрөнгөөр 9-н лифтийг шинэчлэх ажил хийгдсэн байна.	
57	2.86.Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе	1. Аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2016 - 2018	112,0 сая төг	Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд 147.2 тэрбум төгрөгийн 134 төсөл арга хэмжээ хэрэгжихээр тусгагдсан. Үүнээс аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр 2019 онд 112.0 тэрбум төгрөгийн нийт 96 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 2019 онд шинээр 79 төсөл арга хэмжээ, 2019-2020 онд 17 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжинэ. Дээрх 96 төсөл арга хэмжээний ХАА зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулан барилга угсралтын ажил хийгдэж байна. Барилга угсралтын гэрээ байгуулсан ажлын гүйцэтгэлийн явц 90%-тай байна. Мөн нийслэл, 13 аймаг орон нутаг томилолтоор ажиллаж 2018-2019 онд улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 46 төсөл арга хэмжээ, төслүүдийн хүрээнд инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн барилга угсралтын ажлын	100%

	шаттай хэрэгжүүлнэ.					явц байдалтай газар дээр нь танилцаж, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлт гарган, эрчимжүүлж ажилласан. Хавсралт : 4 файл	
58		2. Инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх стандарт боловсруулах	2016 - 2020			Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөнд инженерийн шугам сүлжээг хонгилын системд угсрах, засварлах, турших барилгын дүрэм боловсруулах ажил тусгагдсан. Барилгын дүрмийг 20.0 сая.төгрөгөөр боловсруулах техникийн даалгаврыг 2017.11.24-ний 43/2017 дугаартай баталсан. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу 2019.06.25-ны өдөр барилгын дүрмийн төслийг боловсруулж дуусган, яам болон холбогдох мэргэжлийн байгууллагуудаас санал авахаар хүргүүлж саналыг нэгтгэн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж шүүмж засварыг хийж Барилгын салбарын Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Хавсралт : 4 файл	70%
59		3. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний насжилтийг уртасгах, шинэчлэх, засварлах ажилд шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2016 - 2020			Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг шуудуугүй технологиор доторлох төслийг Ус сувгийн удирдах газар 2018 оноос хэрэгжүүлж эхэлсэн. 2018 онд нийт 4,4 км шугам хоолойг доторлохоор төлөвлөн ажилласан боловч шугам доторлогооны техник, тоног төхөөрөмж хугацаандаа нийлүүлэгдээгүйн улмаас шугам доторлогооны ажил 2019 оны 9 дүгээр сарын 6 –ны өдрөөс Сөүлийн гудамжны Ф150мм-ийн ширмэн 1,6 км шугамыг доторлох ажлаар эхэлсэн ба шугамыг нийт 4 хэсэгт хувааж ажлыг гүйцэтгэсэн. Үүнд 1,2 дугаар хэсгийн 720 метр шугам хоолойг 2018 оны 9 дүгээр сарын 6 –ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж дуусгасан. 2019 онд нийт 9,6 км шугам хоолойг доторлохоор төлөвлөн ажилласан бөгөөд Сөүлийн гудамжны доторлоогүй үлдсэн 3,4 хэсгийн 850 метр шугам хоолойг 2019 оны 5 дугаар сарын 9 –ний өдрөөс 6 дугаар сарын 2 –ны өдрийн хооронд ажлыг гүйцэтгэж 1,6 км шугамыг 100 хувь ажиллагаанд оруулсан. Хавсралт : 1 файл	100%
60	2.87.Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн	1. Угсармал барилгын үйлдвэрлэлийг дэмжих	2017 - 2020	23 сая доллар		Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 180, 2014 оны 113, 2015 оны 319 дүгээр тогтоолууд батлагдсаны дагуу Монгол Улсын Хөгжлийн банк “Эрэл” ХХК-тай 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдөр 3-БҮК/ХО 2013-143 тоот зээлийн гэрээ байгуулан 14,0 сая ам долларын зээл, 2015 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 3-БҮК/ХО 2015-82 тоот зээлийн гэрээг байгуулан 9,0 сая ам долларын зээлийг тус тус өгч,	100%



	хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.				<p>“Эрэл” ХХК-ний “Байшин үйлдвэрлэх комбинат-1” төслийг хэрэгжүүлэн ажилласан. “Эрэл” ХХК-ний БҮК-1 төслөөр байгуулсан угсармал бетон хийцийн барилгын материалын үйлдвэрийг ашиглалтанд оруулж тус үйлдвэрийн хийц бүтээцээр 36 айлын орон сууцны барилгыг барьж ашиглалтад оруулаад байна. “Угсармал төмөр бетон хавтгаалжин хийц, бүтээцийн хэсэглэлийн цомгийн бүрдэл”-ийг Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 52 дугаар тушаалаар баталж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 04 сарын 03-ны өдрийн 4330 дугаарт бүртгүүлэв. - Барилгын материал бүтээгдэхүүний баталгаажуулалтын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хурлаар “Эрэл” ХХК-ийн үйлдвэрлэж буй хучилтын төмөр бетон нүхт хавтанд 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ олгосон. - Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтын хүрээнд “Эрэл” ХХК-ийн угсармал бетон бүтээцээр эрчим хүчний хэмнэлттэй жишиг барилгыг нийтэд сурталчилах зорилгоор Германы олон улсын байгууллагын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэй бариулж, сурталчилгааны нээлтийг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Хавсралт : 1 файл</p>	
61		2. Барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй барилгын дулаалгын материалын үйлдвэрүүдийг бодлогоор дэмжих	2017 - 2020		<p>Барилгын дулаан алдагдлыг 20 хувиар бууруулах ажлыг дэмжих зорилтын хүрээнд дулаалгын материалын үйлдвэрүүд эрчимтэй хөгжиж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байна. Дулаалгын материал үйлдвэрлэгчдийн материалыг хэрэглэгчдэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг үзэсгэлэнгийн ажлуудаар зохион байгуулалттайгаар хийж байна. БХБЯам, “Мишээл Экспо” ХХК-тай хамтран зохион байгуулсан “УЛААНБААТАР БАРИЛГА-2019” үзэсгэлэнд нийт 100 гаруй үйлдвэрлэгчид оролцож өөрсдийн үйлдвэрийн бүтээгдэхүүнээ танилцууллаа. - Тогтвортой ногоон барилгын үнэлгээний систем, санхүүжилтын арга механизм сэдвээр семинар, хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр 60 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, Барилга.мн сэтгүүл, Ийгл телевизд барилгын яамнаас хийж буй ажлын талаар мэдээ, мэдээлэл өгсөн. - НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Барилгын салбараас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг тоолох хэмжих үндэсний арга хэмжээ” төсөл, Германы олон улсын байгууллагын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын барилгын салбар дахь эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслүүдийн дэмжлэгээр “Барилгын дулаан хамгааллын үзүүлэлтийг тодорхойлох” судалгааны ажил</p>	100%

					хийж гүйцэтгэсэн. - НЗДТГ, ДДНХБ /GGGI/ байгууллагын хамтран хэрэгжүүлж буй “Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл” төслийн оролцогч талуудын уулзалтад тус яамнаас холбогдох мэргэжилтнүүд 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдөр оролцож санал өгсөн. - GIZ төслөөс Эрчим хүчний хэмнэлттэй АОС-ны загвар байшин танилцуулах Нээлтийн арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж, “Эрэл” ХХК, “Изохаус” ХХК, “Дэлгэр констракшн” ХХК-иудын барьсан 50 м2 бүхий барилгыг танилцуулсан. - Мөн НАМА төслийн хүрээнд барилгын эрчим хүчний алдагдлыг бууруулах загвар төслүүдийг Говь алтай, Дундговь зэрэг аймгуудын төсвийн байгууллагын зарим барилга, байгууламжуудад хэрэгжүүлсэн.	
62	3. Шилний үйлдвэр байгуулах төслийг бодлогоор дэмжих	2017 - 2020	-		Шилний үйлдвэр байгуулах төслийг бодлогоор дэмжин ажиллах зорилтын хүрээнд “Эрдэс плазм” ХХК-нь Монгол Улсад шилний үйлдвэрт ашиглаж болох ордын судалгааг хийж дуусаад байна. Төслийг дэмжиж ажиллахыг хүссэн БХБСайдын 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 02/4096 тоот албан бичгийг Хөгжлийн банкинд хүргүүлээд байна. Мөн энэхүү үйлдвэр ашиглалтад орсноор Монгол Улсын шилэн бүтээгдэхүүний хэрэглээг дотооддоо бүрэн хангах боломжтой ба тус компаний боловсруулсан төслийг БХБЯ-аас хууль тогтоомжийн дагуу бүхий л талаар дэмжиж ажиллах тухай 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/4481 албан бичгийг ирүүлсэн хүсэлтийн дагуу тус байгууллагад хүргүүлсэн. Шилний үйлдвэрийг дэмжих зорилтын хүрээнд шилний багц стандартыг боловсруулах ажлыг Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган 5 стандарт боловсруулж, 3 стандартыг батлуулж, 2 стандарт Барилгын салбарын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. Хавсралт : 1 файл	100%
63	4. Баруун бүсэд байгуулах цементийн үйлдвэрийг дэмжих	2017 - 2020			Баян-Өлгий аймагт “Өлгий-Цемент” ХХК-ийн цементийн тээрмийн үйлдвэр баригдаж, 42,5 -52,5 маркийн 150 тонн цемент үйлдвэрлэсэн. Баруун аймгуудад 1 тонн цемент 340000 төгрөг буюу 1 уут цемент 17000-18000 төгрөгөөр борлуулагдаж байсан бол энэ үйлдвэр ашиглалтад орсоноор 1 тонныг 260 мянган төгрөг буюу 1 уут цементийг 13 мянган төгрөгөөр борлуулсан байна. Барилгын материалын үйлдвэрлэлд тусгай зөвшөөрөл олгох ажлын хэсгийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаас “Өлгий-Цемент” ХХК-д цемент үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгосон. Энэхүү үйлдвэр ашиглалтад орсоноор баруун бүсийн цементийн хэрэгцээг	100%

					бүрэн хангах боломж бүрдээд байна. Мөн Ховд аймгийн Буянт суманд “Ховд эко цемент”-ийн үйлдвэрийн барилгын ажил 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр нээлтээ хийсэн. Засгийн газрын 21:100 хөтөлбөрт багтсан энэхүү үйлдвэр нь жилд 300 мянган тн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн цементийн хэрэглээг 100 хувь хангахаар төлөвлөж байна. Тус компани цементийн үйлдвэрийн ТЭЗҮ-ээ зохих шатны хурлуудаар хэлэлцүүлэн зөвлөмжийг төсөлдөө тусгаснаас гадна байгаль орчны нарийвчилсан үнэлгээг БОАЖЯ-аар батлуулсан.	
64	2.88.Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, шаттай хэрэгжүүлнэ.	1. Улаанбаатар хот, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн 1:10000 масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалд үндэслэн газар хөдлөлтийн барилгын норм, дүрмийг шинэчлэх	2017 - 2018		Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар 2012-2015 онд Одон орон, геофизикийн хүрээлэн Улаанбаатар хот болон Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн 1:10000 масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг боловсруулсан. Тус зургийг Шинжлэх ухааны Академийн Ерөнхийлөгчийн 2016 оны А/201 дугаар тушаалаар, “Газар хөдлөлтийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм” /БНБД 22-04-16/-ийг Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 198 дугаар тушаалаар тус тус батлуулж Улаанбаатар хот болон бусад дагуул дүүрэг, Барилгын хөгжлийн төв зэрэг зураг төслийн байгууллагуудад хэрэгжүүлж ажиллуулах үүргийг өгсөн. Мөн “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” /БНБД 22-01-01*/2006/-ийг шинэчлэн боловсруулж, Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Холбогдох гишүүдээс ирүүлсэн саналын дагуу төслийг Барилга бүтээцийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар дахин хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийн дагуу дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулахаар бэлэн болоод байна. Хавсралт : 1 файл	70%
65		2. Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи,	2016 - 2019		БХБЯ, ОБЕГ, ООГХ хамтран баталсан 2018 оны 2018/175 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу 2018 онд эхлүүлсэн “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил”-ыг үргэлжлүүлэн хийхэд шаардлагатай 2 тэрбум төгрөгнөөс 2019 оны улсын төсөвт 400.0 сая төгрөг суусан. Эхний шатны тайланг 2018 онд хүлээн авсан ба хоёрдугаар шатны тайланг 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 53 тоот албан бичгээр авч, захиалагчийн хяналтыг хийхээр Газар, зохион байгуулалт геодези зураг зүйн газарт 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 03/1184	70%

		гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлыг хийж дуусгах				тоот албан бичгээр хүргүүлээд байна. Захиалагчийн хяналтын хийсэн тухай албан бичгийг 05 дугаар сарын 23-ны өдрийн 1/1017 тоот албан бичгээр хүлээн аваад байна. Мөн 2020 оны Төсвийн тухай хуульд шаардлагатай байгаа үлдэгдэл санхүүжилтийн төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. 2020 оны Төсвийн тухай хуульд тусгагдаагүй. Хавсралт : 1 файл	
66		3. Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг хэрэгжүүлэх	2016 - 2020	400,0 сая төг		Аймаг орон нутагт 8621 барилга байгаагаас 74% барилга байгууламжид паспортжуулалтын ажил хийгдээгүй мөн газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжийн тоо 1435 байна гэсэн судалгаа гарсан. “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Барилга, хот байгуулалтын яамнаас аймаг, нийслэлийн Засаг дарга нарт өөрийн нутаг дэвсгэрт хамаарах нийт барилга байгууламжид паспортжуулалт хийсэн болон 2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг ирүүлэх, цаашид уг ажлын эрчимжүүлж ажиллах талаар 01/313 тоот албан бичгээр 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн. Мөн уг журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус паспортжуулалтын зөвлөл 21 аймаг болон нийслэлд байгуулагдаад байна. Мөн шаардлагатай хөрөнгийг Төсвийн тухай хуульд жил бүр тусгаж ажиллах, паспортжуулалтыг хэрхэн хийх талаарх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Барилга байгууламжийг паспортжуулах ажилд Улаанбаатар хот 250 сая, Орхон аймаг 25 сая, Говь-Сүмбэр аймаг 50 сая, Өмнөговь аймаг 100 сая төгрөгийг тус тус 2019 оны төсөвт тусгаж, хэрэгжүүлэн ажиллаж нийт 89 барилга байгууламжид газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах, паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Хавсралт : 1 файл	100%
67		4. Газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах	2016 - 2020			Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 6627 орон сууц ашиглагдаж байгаагаас ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн орон сууцны зориулалттай барилга нийслэлд 349, орон нутагт 702, үүнээс мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглахыг хориглосон нийслэлд 234, орон нутагт 221 барилга байна. Аймгийн төв, томоохон хот сууринд дээрхтэй адил нөхцөл байдал үүссэн 221 орон сууцны барилга байгаа бөгөөд орон нутагт орон сууцны үнэ Улаанбаатар хотоос хэт доогуур учир Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Орон сууцны тухай хуулийн дагуу ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай	100%

					<p>орон сууцны оронд шинээр барилга барих хөрөнгө оруулагч, хөрөнгийн эх үүсвэр олддоггүй бэрхшээл нийтлэг болоод байна. Архангай, Баянхонгор, Дархан Уул, Өмнөговь, Хөвсгөл, Төв зэрэг аймгууд өөрийн төсөвтөө холбогдох зардлын төсвийг суулган ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилга байгууламжийг буулган шинээр барих ажлыг зохион байгуулан ажиллаж байна. “Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй буулгаж, шинээр барих шаардлагатай барилга байгууламжийн жагсаалт”-д багтсан барилга байгууламжуудыг 2020 онд шаардлагатай байгаа төсвийг тусгуулах талаар төслөө Сангийн яаманд саналаа хүргүүлсэн. Нийслэлд 163 барилгыг 67 багц болгон төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2019 оны байдлаар 12 удаа зарласан байгаагаас 29 багцын 75 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдсаны үр дүнд одоогийн байдлаар 531 айлын 27 орон сууцыг буулган 1054 айлын 11 орон сууц ашиглалтад орсон байна. 2019 оны 4 дүгээр улиралд багтаан 4 орон сууц шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Аймаг орон нутгийн хэмжээнд 6 орон сууц, 1 сургууль, 2 хичээлийн байр, 2 соёлын төв, 1 асрамжийн барилгыг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна.</p>	
68		<p>5. Газар хөдлөлтийн лаборатори байгуулах, техник, тоног төхөөрөмж нийлүүлэх, хүний нөөцийг сургаж бэлтгэх ажлыг зохион байгуулах</p>	2017-2020	-	<p>УИХ-ын 2016 оны 34 дүгээр тогтоол, УИХ-ын Эдийн засаг, Аюулгүй Байдлын Байнгын Хорооны 2018 оны 05/13 тогтоолуудын хүрээнд барилгын материалын лабораторийн дүрмийг дахин боловсруулж байна. Өнөөдрийн байдлаар бүсийн тулгуур барилгын материалын лабораторийн төв болохоор төлөвлөж байгаа Ховд, Дорноговь, Архангай, Орхон, Хэнтий, Сүхбаатар аймгуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар лабораторийн барилга баригдсан. Барилгын материалын лабораториуд нь дээрх тоног төхөөрөмжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа барилгын материалын лабораториудаас Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Завхан, Төв, Булган, Говьсүмбэр, Дундговь, Сэлэнгэ аймгууд лабораторийн барилгагүй үйл ажиллагаа нь жигдрээгүй зөвхөн байгаа тоног төхөөрөмжийн хүрээнд туршилт хийж байна. Улсын төсөвт төв болон аймгуудын лабораториудыг өргөжүүлэх, тоног төхөөрөмж нэмэгдүүлэх санал хүргүүлдэг боловч улс орны эдийн засагтай холбоотойгоор үр дүн хүрэхгүй байна. Өнөөдрийн байдлаар Ховд, Дорноговь, Архангай, Орхон, Хөвсгөл, Баян-Өлгий, Баянхонгор аймгууд СХГазрын итгэмжлэлийн газраар</p>	100%

					итгэмжлүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Хэнтий, Төв, Булган, Говь-Алтай, Говь-сүмбэр, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ аймгууд итгэмжлэгдээгүй байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа барилгын материалын лаборатори хариуцсан мэргэжилтнүүд нь орон нутгийн ГХБХБГазарт харьяалагдан ажиллаж байна. 2020 оны улсын төсөвт 21 аймгийн барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэхээр 9.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг суулгасан. Мөн уг лабораторуудад ажиллах мэргэжилтнүүдийг орон тоог нэмэгдүүлэхээр 6.5 тэрбум төгрөгийг тусгуулан батлуулсан.	
69	2.89.Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.	1. Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах	2016 - 2018		-Бодлогын баримт бичгийн төсөлд Барилга, хот байгуулалтын сайдын 2019.08.22-ны өдрийн 01/3204 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга, нийслэлийн Засаг даргаас санал авч нэгтгэсэн. Бодлогын баримт бичгийн төслийг Барилга, хот байгуулалтын Сайдын зөвлөлийн 2019.12.03-ны өдрийн 09 дүгээр хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Сайдын зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусган, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, нийтлэг журамд заасан шаардлага хангасан иж бүрдэл материалын хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2019.12.06-ны өдөр 01/4542 тоот албан бичгээр тус хүргүүлсэн. -Сангийн сайдын 2019.12.24-ны өдрийн 5-2/8449 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг хүлээн авч бодлогын төсөлд тусган Сангийн яаманд дахин хүргүүлж зөвшөөрөл авснаар Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэн батлуулах, хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахаар ажиллаж байна. Хавсралт : 5 файл	100%
70		2. Нийтийн аж ахуйн салбарт олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн асуудлыг шийдвэрлүүлэх	2016 - 2020		Салбарын Дамжуулан зээл, зээлийн хүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх шинэчилсэн судалгаа, тооцоо бүхий саналыг Сангийн сайдад 2019 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 01/4634 тоот албан бичгээр дахин хүргүүлсэн. Сангийн яам улсын хэмжээний дамжуулан зээлдүүлсэн зээлүүдийг төсөвт дарамт бага байхаар шийдвэрлэх бодлогыг баримталж байгаа бөгөөд зээлийн асуудлыг цогцоор нь Засгийн газарт танилцуулж улмаар УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх чиглэл барин ажиллаж байна. Хавсралт : 1 файл	100%

71		3. Инженерийн хангамжийн өндөр болон дэвшилтэт технологийн тоног төхөөрөмжүүдийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлүүлэх санал боловсруулж, тухай бүр шийдвэрлүүлэх	2017 - 2020		Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр Сангийн Сайд Ч.Хүрэлбаатарт 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/2366 тоот, 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 02/822 тоот албан бичгүүдээр Сангийн яаманд хүргүүлсэн. Сангийн яамнаас Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр батлуулсантай холбогдуулан татварын багц хуулийг тодорхой хугацаанд хэрэгжүүлэн, үр дүнг дүгнэх хүртэл өөр бусад татварын хууль тогтоомжоор татварын хувь хэмжээг бууруулах, давхардсан хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх шаардлагагүй талаар дурдсан 2019 оны 4-2/1789 тоот албан бичгийг яаманд ирүүлсэн. Хавсралт : 3 файл	100%
72	2.90.Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг	1. Шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг цэвэршүүлэн ариутгах татуургын систем, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах боломжит технологийг судлан, барилгын зураг төсөлд тусгах санал боловсруулж хэрэгжүүлэх	2017 - 2020		-Бохир усыг цэвэршүүлэн ариутгах татуургын систем, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах Стандартын төслийг эхний хувилбараар боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэн санал авч, батлуулах ажил үргэлжилж байна. Ногоон барилгын загвар төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд ногоон орон сууцны барилгын зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт ундны цэвэр усыг тусад нь төлөвлөхөөр тусган ажиллаж байна. -Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн усыг ариутгах татуургын технологийн хэрэгцээнд, суултуур зайлах, нүүрс угаах, зам, талбайн тоос дарах зэрэг арга хэмжээнд ашиглах "Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага. MNS 6734:2018 стандартыг, цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглах MNS ISO 16075 багц стандартыг Стандартчилал хэмжил зүйн газрын Байгаль орчны стандартчиллын техникийн хорооны 2018.10.18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Стандартууд батлагдсанаар барилгын зураг төсөл боловсруулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Мянганы сорилтын сангийн төслийн хүрээнд Төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн усыг дахин боловсруулан дулааны станцид ашиглах "Ус дахин боловсруулах" үйлдвэр барихаар ажиллаж байна. Хавсралт : 1 файл	100%

	төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.					
73	2.91.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.	1. АХБ-ны зээлээр “Дархан хотын бохир усны менежментийн төсөл”-ийг хэрэгжүүлэх	2017 - 2020	1.732.3 сая төг	1. Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, гадна тохижилт, зай хэмжээ, технологийн шугам сүлжээ, гадна цахилгаан, гадна холбооны зураг төслийг 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр магадлалаар батлуулсан. Зураг төслийн ажлын явц 97%. 2 Цэвэрлэх байгууламжийн нийт 39 барилга, 3 насос станцын засвар шинэчлэлийн ажлын явц 2019 оны жилийн эцсээр өссөн дүнгээр 64.9% байна. 3. Дулааны болон бохирын шугам шинэчлэлийн хүрээнд 2019 онд нийт 6.9км шугам шинээр угсарч, 4.6 шугам сэргээн засварлаж ашиглалтад оруулсан. 4. Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхыг бэхжүүлэх хүрээнд 2019 онд зохион байгуулсан нийт 9 сургалтад 335 хүн хамрагдсаны 110 нь эмэгтэй оролцогч байна. 5. Төслийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний биелэлт өссөн дүнгээр 2019 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар 76.00 хувийн, төслийн 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээ 81.00 хувийн биелэлттэй байна. Хавсралт : 5 файл	100%
74		2. АХБ-ны зээлээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийг хэрэгжүүлэх	2017 - 2020	4.853.9 сая төг	1.Өвөрхангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барьж 2018.11.15-ны өдөр, Архангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барьж 2019 оны 10 дугаар сард тус тус ашиглалтад оруулсан. 2. Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын гүйцэтгэл -70 хувьтай байна. 3.Дорноговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын гүйцэтгэл 40%-тай байна. 4. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах 2.5 км цэвэр усны шугамын ажлын зураг төслийг 2019.07.14-ний өдөр магадлалаар баталгаажуулсан. Ус дулаан дамжуулах төвийн дулаан хангамжийн 2-р хэлхээний 0.38 км, цэвэр усны эх үүсвэрийн 2.5 км шугамын ажлыг гүйцэтгэж, 2019.12.05-ны өдөр ашиглалтад оруулсан. 5. Өвөрхангай аймгийн Хужирт суманд 310 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсөл, тендерийн баримт бичгийн төслийг АХБ хянаж, тендер зарлах зөвшөөрлийг 2019.10.25-ны өдөр ирүүлсэн. Тендерийг 2019.11.02-ны өдөр зарлаж, 2019.12.02-ны өдөр тендерүүд хүлээн авч нээн, үнэлгээ хийж 2019.12.12-ны өдөр АХБ-д хүргүүлээд байна. Хавсралт : 1 файл	100%
75		3. Улаанбаатар хотод хоногт 20,000 м.куб бохир ус	2016 - 2019		Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг эхлүүлж, 17,6 га талбайд баригдах шинэ цэвэрлэх байгууламжийн зураг төслийг Шанхайн зураг төслийн хүрээлэнд боловсруулж, 2019	100%



	цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулах				оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ЭЗ-5/2019 тоот ерөнхий дүгнэлтээр магадлал хийлгэн баталгаажуулсан. Цахилгаан хангамжийн 45/2019, дулаан хангамжийн 145с/2019/87, холбоо дохиоллын ТН-В546/2019 тоот техникийн нөхцөлүүдийн сунгалт хийгдсэн. Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэн батлуулсан. Цэвэрлэх байгууламжийн барилгын ажилд хэрэглэгдэх 120м3/цаг хүчин чадалтай бетон зуурмагийн 2 узелийг угсарч, БМУ-БЭ-376/2019 тоот технологийн зааврыг батлуулсан. Узелийн машин механизм, тоног төхөөрөмжүүдийг шалгаж, МХЕГ-ын №1800000104 тоот аюулгүй ажиллагааны гэрчилгээгээр баталгаажуулсан. Барилга байгууламжийн ажил эхлүүлэх 01/2019 тоот зөвшөөрөл авсан. Зөвшөөрлийн дагуу төслийн барилга угсралтын талбайн бэлтгэл ажлыг хангаж түр ажилчдын байр, хашаа, цамхагт краныг байршуулан, биологи цэвэрлэгээний байгууламжийн суурийн газар шорооны ажил, бетон зуурмагийн узель угсрах, байгууламжийн суурийн ул бетон цутгах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Төслийн нийт төсөвт өртөг 262,7 сая.ам. доллар. Хавсралт : 1 файл	
76	4. Цэвэрлэх байгууламжийн хяналтын лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчнийг чадавхижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	2019 - 2020			-Архангай, Өвөрхангай аймгийн төвд шинээр баригдсан (3000 м3/хон) цэвэрлэх байгууламжид насос тоног төхөөрөмж, шугам сүлжээ, лабораторид вакум насос, шил сав хатаагч, спектрометр, усан банн, татах шүүгээ, ус нэрэгч, аналитик жин, усны орчин, температур хэмжигч, хутгагч, шинжилгээний шил сав зэргийг нийлүүлсэн. - Архангай, Өвөрхангай аймагт 2019 оны 8 дугаар сард, Өмнөговь аймагт 2019 оны 5 дугаар сард лабораторийн ажилтнуудад чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулсан. -Улаанбаатар хотын УСУГ-ын Усны төв лабораторт 2019 оны 6, 7 сард Өвөрхангай аймгийн "Онги ус" ХХК, Архангай аймгийн "Ар ус ундарга" ХХК-ны химич нар, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын "Чандмань бадрал" ХХК-ны байцаагч инженерүүд ажлын 5-7 хоног мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдсан. -"Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" мэргэжлийн ТББ 2019 оны 11 дүгээр сарын 04-08-ны өдрүүдэд Усны шинжилгээний лабораторийн химич, бактерлогичийг чадавхижуулах сургалт зохион байгуулсан.	100%
77	5. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид лагийг бүрэн боловсруулах, дахин ашиглах технологи	2016 - 2020	12.961 сая төг		"Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх" төсөл, арга хэмжээний хүрээнд 2019 оны улсын төсөвт 12,5 тэрбум төгрөг тусгаж, дараах арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд: 1. Эрдэмтэн Х.Дугаржав нарын зохион бүтээсэн гумины бордоог ашиглан 111500 м2 талбайг хучиж 15-25 см зузаантай үе үүсгэн ялзралыг зогсоох түр арга хэмжээ авсан. 2.ОХУ-д үйлдвэрлэсэн биологийн	100%

		нэвтрүүлэх асуудлыг үе шаттай шийдвэрлүүлэх			бүтээгдэхүүнийг ашиглан доктор Д.Басандоржийн аргачлалаар 26196 м3 лагийг боловсруулж хар шороон хөрс болгох ажлыг гүйцэтгэсэн. 3.Япон Улсын эрдэмтдийн гарган авсан идэвхжүүлсэн бактери ашиглан цэвэрлэх байгууламжийн 44 ширхэг картанд байсан 360265 м3 лаг, өдөр тутам гардаг 1200 м3 (153 өдрийн турш гарсан 183600 м3) түүхий лаг, 241164 м3 хур лаг, нийт 810878 м3 лагийн үнэрийг дарах, бордоо болгох, талбай картуудыг суллах ажлыг гүйцэтгэсэн. 4.Төв цэвэрлэх байгууламжид лаг усгүйжүүлэх технологийн дамжлагыг 2019 оны 9 дүгээр сард ашиглалтад оруулснаар өдөрт ялгардаг 1200 м3 түүхий лагийг ил задгай 3-5 жилийн хугацаанд хатаадаг байдал зогсож, өдөрт нь механик болон химийн аргаар усгүйжүүлснээр лагийн үнэр, овор хэмжээг 6-9 дахин багасгав. 5. Бохир ус цэвэрлэгээний явцад болон хаягдал лагийн үнэрт бодисын тархалт, бохирдуулагч бодисын агууламжийн судалгаа, шинэжилгээг лабораторийн аргаар боловсруулан үндэсний болон олон улсын стандарттай харьцуулан тогтоосон. Үнэр тархалтыг бууруулах техникийн дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээ авч цэвэрлэх байгууламж дотор 8 цэг, байгууламжийн эргэн тойрон суурьшлын бүсийн 12 цэгт 9 төрлийн үнэр тархалтын дээж авч, лабораторийн дүн шинжилгээ хийлгэх, тархалтын математик загварчлал гаргуулах ажлыг гүйцэтгүүлсэн. Хавсралт : 1 файл	
78	2.92.Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах	1. Хур борооны усны багц стандартыг боловсруулж, батлуулах	2016 - 2018		Хур борооны усыг хуримтлуулах, ундны бус зориулалтаар түгээх системийн зураг төсөл боловсруулах, угсрах, шалгах, засвар үйлчилгээ хийхэд Их Британи Улсад мөрддөг BS 8515 2016 стандартыг орчуулсан. Энэхүү стандарт нь айл өрх, худалдаа үйлчилгээ, нийтийн үйлчилгээний газруудын угаалга, ариун цэврийн өрөө, зүлэг усалгаа зэрэг чанарын хувьд ундны бус зориулалтаар ахуйн хэрэглээнд ашиглах системд хамаарна. Борооны ус хуримтлуулах систем. Хэрэглээний дүрэм. MNS BS 8515: 2019 стандартын төслийг боловруулж, 2019.12.03-ны өдрийн Стандартчилал хэмжил зүйн газрын Байгаль орчны техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж батлагдсан. Хавсралт : 1 файл	100%
79	боломжийг бүрдүүлнэ.	2. Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх	2017 - 2018		Төв цэвэрлэх байгууламжаас гарсан бохир усыг дахин боловсруулж, цэвэрлэсэн усыг ашиглах зорилго бүхий “Хаягдал ус дахин боловсруулж үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах төсөл”-ийг АНУ-ын “Мянганы сорилтын корпораци”-аас /МСК/ Тетра Тех төслийн баг боловсруулж ашиглах судалгаа, техникийн тайланг БХБЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Уг төслөөр Дулааны	70%

					цахилгаан станцуудын /ТЭЦ-3, ТЭЦ-4 станцуудын/ гүний усны хэрэглээг бууруулах, шинээр баригдах төв цэвэрлэх байгууламжтай залгуулан 50000 м3/хоногийн хүчин чадал бүхий бохир ус дахин боловсруулах байгууламжийг барьж байгуулахаар төлөвлөсөн ба нөөцийн сав, шахуурга станц болон дамжуулах шугам хоолой зэрэг дэд бүтцийг зураг төсөл, угсралтын ажлын хамт төлөвлөсөн ТЭЗҮ-г МСК боловсруулсан. - Хөрсний усыг үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах найрлага шинж чанарыг нарийвчлан судлах, цаашид ямар технологиор бүрэн цэвэршүүлж болох судалгааны ажил хийхэд шаардагдах төсвийн тойм болон хөрсний усыг ашиглах төслийн саналыг ШУТИС-ын дэргэдэх Усны судалгааны төвөөс ирүүлсэн бөгөөд энэ асуудлын хүрээнд шийдэж болох асуудлыг хянан судалж байна. Хавсралт : 1 файл	
80		3. Цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгдсэн усыг усалгаанд ашиглах заавар, багц стандартыг боловсруулж батлуулах	2017 - 2019		Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах гарын авлага" багц стандартыг "Ус хэлц" ТББ боловсруулан 2018.10.18-нд Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, СХЗГазрын даргын 2018.12.26-ны с/07 дугаар тушаалаар батлагдсан. Хавсралт : 2 файл	100%
81		4. Цэвэрлэсэн усыг үйлдвэрлэлийн зориулалтаар эргүүлэн (дахин) ашиглах технологийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	2018 - 2020		1.Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоолын дагуу Төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлэх бохир усны стандартыг хангуулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулав. Энэ ажлын хүрээнд: а) Нийслэлийн Эмээлт хөнгөн үйлдвэрийн паркийн төслийн нэгж, Арьс ширний үйлдвэрийн холбооны төлөөлөгчдийг байлцуулан хуралдаж ТЭЗҮ, ажлын зураг төсөл, явцтай танилцсан. "Харгиа", Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд үүсээд байгаа хүндрэлийг арилгах зорилгоор Барилга, хот байгуулалтын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, нийслэлийн Засаг дарга хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, ажлын төлөвлөгөө гарган цаашид хийх ажлуудыг тодорхой болгон ажиллаж байна. б) Ус бохирдуулагч үйлдвэр, аж ахуйн нэгжийн дунд 2019.05.08-ны өдөр зохион байгуулсан сургалт, семинараар урьдчилан болон бага хүчин чадлын цэвэрлэх байгууламжийн худалдаа, угсралт, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын 200 гаруй төлөөлөгчийг хамруулан танилцуулга хийж, цаашид баримтлах чиглэлийг тодорхойлсон. в) Мянганы сорилтын корпорацитай хамтран Ус дахин боловсруулах үйлдвэр барих төсөл болон ундны усны шинэ эх үүсвэр байгуулах	100%

					төслүүдийг уялдуулах үүрэг бүхий Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дахин цэвэрлэж дулааны цахилгаан станцуудад нийлүүлэх төслийн урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл, ус дахин боловсруулах техникийн шаардлагуудыг тус тус боловсруулаад байна. Хавсралт : 1 файл	
82	2.94.Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ.	1. "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан "Туул усан цогцолбор" барих төслийн зураг төсөв, "Туулын шугуй цогцолбор-зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах төсөл", "Туул, Сэлбэ голын орчныг сэргээн сайжруулах төсөл" зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлыг НЗДТГ-тай хамтран боловсруулж, батлуулах	2016 - 2020		<p>"Дугуйн зам" дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу Улаанбаатар хотын төвийн хэсэгт болон Сэлбэ, Туул гол дагасан унадаг дугуйн замын трассыг судалж, 2017.03.24-ний өдрийн Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.</p> <p>Гадаргын ус хуримтлуулах "Туул усан сан цогцолбор" төслийн ТЭЗҮ-г Монголын "Престиж инженеринг" ХХК, БНСУ-ын "Юүшин инженеринг" ХХК хамтран боловсруулж, Нийслэлийн Засаг даргын 2016.12.23-ны өдрийн А/915 дугаар захирамжаар хараат бус хөндлөнгийн шинжээчид томилогдон ТЭЗҮ-ийг хянан дүгнэлт гаргасан. Засгийн газрын хуралдааны 2018.10.10-ны өдрийн 42 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс тус арга хэмжээг хасуулах саналыг тайлбар, үндэслэлийн хамт 2018.10.31-ний өдрийн 01/4214 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>БХБЯ-ны Санхүүгийн хэлтсээс 2020 оны төсвийн төсөлд БХБ-ын сайдын багцад тусгагдах төсөл, арга хэмжээний жагсаалтад "Туул усан цогцолбор" төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад шаардлагатай 4,100.0 төгрөг тусган СЯ-нд хүргүүлсэн боловч тусгагдаагүй болно. 2019 оны төсөвт санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй болно.</p>	Үнэлэх боломжгүй

83	2.95.Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорхи болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ.	1. Авто зогсоолын тухай хуулийн төслийг боловсруулах	2016 - 2017		Авто зогсоолын тухай хуулийн төслийг боловсруулан Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамтатган боловсруулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Хот байгуулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулж ХЗДХ-ийн болон БХБ-ын сайдаар 2019.02.14-ний өдөр тус тус батлуулсан. Хуулийн төслийг БХБ-ын сайдын зөвлөлийн хурлаар 2019.10.22-ны өдөр хэлэлцүүлсэн. Зөвлөлийн гишүүдээс гарсан саналуудыг тусган хуулийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4131 тоот албан бичгээр, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4132 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-ны 2019.12.16-ны өдрийн 6/8231, ХЗДХЯ-ны 2019.12.16-ны өдрийн 1-1/5545 тоот албан бичгээр хүлээн авч, ЗГХЭГ-т 2019.12.17-ны өдрийн 01/4676 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. УИХ-аар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-аас 2019.12.30-ны өдрийн 6/8616, ХЗДХЯ-ны 1-1/5796 тоот албан бичгээр тус тус авч, ЗГХЭГ-аас 2019.12.31-ний өдөр УИХ-ын Тамгын газарт хуулийн төсөл өргөн барих тов тогтоолгох тухай албан бичгийг хүргүүлээд байна. 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн барьсан болно. Хавсралт : 2 файл	100%
84	2.96.Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг дуусгана.	1. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ,	2017 - 2020		УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд шаардагдах хөрөнгөд АХБ, ЕХОБ, НЗДТГ-аас 2019 онд 11.5 сая.ам.долларын санхүүжилт олгосон. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, авто зам, нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын барилга угсралтын нийт ажлын явц 2019.12.10-ний байдлаар 74.2 %-ийн гүйцэтгэлтэй байна. - Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын 2ф700мм-ийн диаметртэй 1,6 км шугам, 2ф600мм-ийн диаметртэй 1,6 км шугам, тохижилт, нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж дуусгаж, 2019.09.18-ны өдрийн 2019/358 тоот комиссын актаар байнгын ашиглалтад оруулсан. Сэлбэ дэд төвийг Чингэлтэй төвийн ус, дулаантай холбох дулааны төв шугамын угсралтын ажлыг 7 буудлын төв зам дагуу 5 буудлаас 7 буудлын уулзвар хооронд 3 цэгт зам сэтэлгээ хийх болсон	100%

		байгууламжийг үе шаттайгаар барьж байгуулах			тул авто замын хөдөлгөөнийг хааж, шугам сүлжээний ажлыг суурилуулж дуусган, замын нөхөн сэргээлтийг хийж, 2019.09.22-ны 02:00 цагт замыг нээсэн. Хавсралт : 2 файл	
85	2.103.Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	1. Хот суурин газрын цахилгаан түгээх сүлжээнд ухаалаг төхөөрөмж, тоолуур нэвтрүүлэх	2016 - 2020		Багануур, Зүүн өмнөд бүсийн 5 аймаг, Эрдэнэт, Булган зэрэг 4 аймагт 74000 ш цахилгааны тоолуурыг суурилуулсан. Диспетчерийн үндэсний төв ТӨХК нь Завхан аймгийн Тэлмэн сум, Увс аймгийн Улаангом сум, Моннаран Нарны цахилгаан станц 50 МВт, Дарханы нарны цахилгаан станц 10 МВт, Цэций салхин цахилгаан станц 50 МВт, ГОК-ын 48 МВт, Ухаахудаг дулааны цахилгаан станц 18 МВт, Гэгээн нарны цахилгаан станц, Хөшигтийн нарны цахилгаан станц, Найдамдал, Буянт-Ухаа болон Шинэ Яармагийн нийт 12 дэд станцуудыг түгээх сүлжээний ухаалаг төхөөрөмж, тоолуурын нэгдсэн системд шинээр холбосон. Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын айл өрхийн халаалтыг цахилгаан халаагуураар шийдэх зорилгоор түгээх сүлжээнд ухаалаг 2 тарифт тоолуур суурилуулж, цахилгааны шөнийн тарифыг тэглэж, айл өрхүүд шөнийн цахилгаан эрчим хүчийг үнэ төлбөргүй хэрэглэж байна. Айл өрхийг 2-4 мВт-ийн хүчин чадал бүхий цахилгаан халаагуур ашиглах эрчим хүчний үнийн хөнгөлөлт үзүүлж байна. Мөн интернетийн сүлжээ ашиглан төв цэгээс удирдах, заалт авах, таслах, залгах боломжтой 2 ба 3 тарифт смарт тоолуурыг амины болон нийтийн орон сууцны хэрэглэгчдэд нэвтрүүлсэн. Хавсралт : 5 файл	100%
86		3. Сумын төвийн шинэчлэл төслийг 16 суманд хэрэгжүүлж дуусгах	2016 - 2020		"Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн хүрээнд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд хийгдэх халаалтын зуухыг 2019.09.25-ын өдөр ажиллуулж хэрэглэгчдийг дулаанаар хангуулсан ба 2019.11.08-ын өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн. - "Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн хүрээнд Дорнод аймгийн Баян-Уул сумын төвийг цэвэр бохир ус, дулаанд холбох, цэвэрлэх байгууламж, хатуу хучилттай авто замын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил 2019.12.15-ний өдөр ашиглалтад оруулах чиглэл өгсөн. -"Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын ерөнхий төлөвлөгөө, дулаан, цахилгаан, холбоо, цэвэр, бохирын гадна сумын инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилт ногоон байгууламжийн зураг төсөл боловсруулж, барилга угсралтын ажлыг	100%

					2019.12.11-ний өдөр комисс ажиллаж ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн. -"Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн Дэлгэр суманд хийгдэж буй Халаалтын зуух, дулаан хангамжийн шугам сүлжээ, холбооны шугам сүлжээг 2019.11.08-ний өдөр комисс ажиллаж ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн. Хавсралт : 2 файл	
87	4.НҮБХХ-ийн санхүүжилтээр “Барилгын салбарт үндэсний онцлогт тохирсон хүлэмжийн хийг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх	2016 - 2019			1.Барилгын дулаалгын ажил 3 байршилд загвар төсөл хэрэгжүүлэх; ШУТИС-ын барилгын дулаалга. Хөрөнгийн асуудлаас болж барилга баригдах боломжгүй болсон тус Загвар төслийг орон сууцанд дулааны тоолуур суурилуулах болон нарны панел суурилуулах загвар төсөл хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж тендерийг зарлаад байна. Хийгдсэн ажил: Худалдан авах ажиллагааг зарласан Гүйцэтгэлийн түвшин: Оноос өмнө гэрээ байгуулсан байна. Үр дүн: Нарны сэргээгдэх эрчим хүч ашиглах, Орон сууцны байрнуудын 24 байрлалд дулааны тоолуур суурилуулна. Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын халаалтын системийн шинэчлэл Хийгдсэн ажил: Урьдчилсан дулаалгатай хоолой, өндөр аүк-той усан халаалтын зуух, ус зөөлрүүлэгч, хувьсах хурдны насос Гүйцэтгэлийн түвшин: Бүрэн хэрэгжсэн Үр дүн: Дулаан алдагдал 30-35 хувиар буурна. Барилгын хөгжлийн төвийн лабораторийн барилгын засварын ажил Хийгдэх ажил: Зоорины ханын дулаалга, гадна ханын дулаалга, цонх сайжруулж солих, шилэн хаалганы шинэчлэл Гүйцэтгэлийн түвшин: Гүйцэтгэсэн, улсын комисс ажиллахыг хүлээж байна. Үр дүн: хэмнэлт нь 23 хувь байхаар байна. Мөн эрчим хүчний ангиллын хувьд “С” ангиллаас “В” ангилалд орно. Эрчим хүчний хэмнэлтийн төвийн өргөтгөлийн барилгын сайжруулалт Хийгдэх ажил: Нарны зайн иж бүрдэл Гүйцэтгэлийн түвшин: Барилга угсралтын ажил 90 орчим хувьтай, нарны зайн системийн угсралт хийгдсэн, тохируулах, турших ажил хүлээгдэж байна. Үр дүн: 30 кВт хүчин чадалтай жилд 6МВт.ц эрчим хүч үйлдвэрлэнэ. 2.Европын Холбооны Улсуудад мөрддөг стандартын шаардлагад нийцүүлэн, Барилгын дулаан хамгаалалтын норм БНБД 23-02-09-ийг шинэчлэн боловсруулах; Барилгын эрчим хүчний хэмнэлтийг дэмжих бодлогын орчныг бий болгох зорилгоор Барилгын дулаан хамгааллын норм ба дүрэм БНБД 23-02-09-ыг олон улсад шинэчлэгдэн мөрдөгдөж байгаа норм дүрмийн дагуу үндэсний онцлогт нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.	100%
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО						

88	3.1.1.Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр боловсруулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.	2.Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх	2017 - 2020		2019 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-тай хамтран Сүхбаатар /2019.4.09-11/ Дорнод, Говьсүмбэр /2019.6-09-13/ аймгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын Ундны эх үүсвэр, байгууламжуудын ашиглалтад хяналт, мониторинг хийж үнэлэлт, дүгнэлт өгсөн. Хавсралт : 3 файл	100%
89	3.1.4.Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар дахин нэмэгдүүлнэ.	8. Эрүүл мэндийн байгууллагуудын агааржуулалтын системийг шат дараатайгаар шинэчлэн сайжруулах	2016 - 2020		Салбарын норм, дүрэм стандартуудад энэ асуудалтай холбогдолтой заалтуудыг тусган оруулсан. Эрүүл мэндийн яамны хариуцах асуудал.	Үнэлэх боломжгүй
90	3.1.15.Эрүүл мэндийн салбарт баригдаж байгаа дуусаагүй барилгуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулах, ашиглалтад орсон барилгуудын ашиглалтын бүтээмжийг сайжруулна.	1. Ахмадын 60 ортой эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлэх	2017 - 2018		Ахмадын 60 ортой эмнэлгийн барилгын ажлыг 2019 оны Төсвийн тухай хуулиар 7.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. 2020 оны Төсвийн тухай хуулиар үлдэгдэл 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Тус төвийн барилга угсралтын шаардлагатай нэмэлт ажлын магадлалаар баталгаажсан төсөв 10.3 тэрбум төгрөгийг 2020 оны Төсвийн тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. Барилгын үндсэн арагт бүтээцийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй. Барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 45 хувийн гүйцэтгэлтэй байна.	70%
91	барилгуудын ашиглалтын бүтээмжийг сайжруулна.	2. Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ортой төрөх эмнэлэг, эх нялхсын эрүүл мэндийн төвийн	2017 - 2018		Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ортой төрөх эмнэлэг эх нялхсын эрүүл мэндийн төвийн барилга барих ажлын хувьд барилгын дулааныг авч, хэсэгчилсэн дотор заслын ажлыг хийж эхэлсэн. Барилга угсралтын ажлын явцад эмнэлгийн барилгын стандарт, болон хуучин зургийн өөрчлөлттэй уялдуулан шаардлагатай нэмэлт ажил хийгдсэн бөгөөд нэмэлт ажлын	100%



		барилгыг ашиглалтад оруулах			магадлалаар баталгаажсан. Е блок /Авто граш/ барилга угсралтын ажил бүрэн дууссан. А, Б, Г, Д блок /эмнэлэг/ барилгын гадна дотор ханын өрлөг бүрэн дууссан. Бетон шалны ажил, цонх суулгах ажил бүрэн дууссан. Шатны бариул, гипсэн тааз угсарсан. Дотор цахилгаан, холбоо дохиолол, сантехникийн босоо шугамын далд холболтын ажил гүйцэтгэж дууссан, холболт тоноглолын ажил үлдсэн. Гадна дулааны шугамын ажил гүйцэтгэж дууссан. ЦТП-ны барилга барьж холболтын ажил хийсэн. Хүчилтөрөгчийн төхөөрөмж байрлах Ж блок барилгын ажил, хаалга цонхны ажил, салхивчийн ажил, сантехникийн ажил дууссан. Гадна зам талбайн тохижилтын ажилд зүлэгжүүлэлтийн ажил, гадна, Дотор заслын ажил гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажил 95%-ийн гүйцэтгэлтэй хэвийн үргэлжилж байна.	
92		3. ХӨСҮТ-ийн био аюулгүй ажиллагааны III зэрэглэлийн лабораторийн барилгыг барих	2017 - 2018		ХӨСҮТ-ийн био аюулгүй ажиллагааны III зэрэглэлийн лабораторийн барилга барих ажлын 2019 оны Төсвийн тухай хуулиар 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. 2020 оны Төсвийн тухай хуулиар 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилгын үндсэн хийцийн ажил бүрэн дууссан, дотор хана, шалны ажлын засал хийгдэж байгаа. Гадна фасад, цонх, хаалганы ажил бүрэн дууссан. Барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.	70%
93		4. ГССҮТ-ийн харьяа Түлэнхийн төвийн барилгыг барьж дуусгах	2017		ГССҮТ-ийн харьяа Түлэнхийн төвийн барилгын ажлын “А”, “С” блокийн барилгыг “Цаст Констракшн” ХХК, “В” блокийн барилгыг “Нутгийн зам” ХХК тус тус гүйцэтгэж байна. Барилга угсралтын явцад С блокийг барихаар төлөвлөгдсөн газрын Нийслэлийн засаг даргын захирамжаар Хөгжлийн Шийдэл ТББ-д олгосоны улмаас барилга барих газаргүй болсон, А блокийн сууринд хөрснөөс ус гарч нэмэлт ажлуудыг гүйцэтгэх шаардлагатай болсон зэрэг асуудлаас шалтгаалан барилга угсралтын ажил удааширч байна. “Нутгийн зам” ХХК-ийн ажлын явц 70%, “Цаст констракшн” ХХК-ийн ажлын явц 90%-тай байна.	70%
94		5. Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийг ашиглалтад оруулах	2016 - 2017		Тус Эмнэлгийн өргөтгөлийн барилгын зураг төслийг “Нарт дизайн” ХХК боловсруулж “Хар чонот” ХХК барилгын ажлыг гүйцэтгэж 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр ашиглалтад оруулах комисс ажилласнаар 03 дугаар сарын 07-ны өдрийн 04/2017 дугаар актаар баталгаажуулан байнгын ашиглалтад хүлээж авсан.	100%
95		6. Ховд аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 50 ортой барилгыг	2016 - 2018		Ховд аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 50 ортой барилгын ажил бүрэн дуусч барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.	100%

		ашиглалтад бүрэн оруулах					
96		7. Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгыг ашиглалтад оруулах	2016 - 2018			2018 оны 12 дугаар сарын 15-нд ашиглалтад орсон. Комиссын акт баталгаажсан.	100%
97		8. Говь-Алтай аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг барих	2016 - 2017			Барилгын ажил 2018 онд дуусч ашиглалтад орсон. Акт баталгаажсан	100%
98		9. Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх тасгийн барилгыг ашиглалтад оруулах	2016 - 2018			Говь-Алтай аймгийн 50 ортой төрөх эмнэлгийн барилга угсралтын ажил нь 2011 онд эхэлсэн. Тус ажлыг "Лайт капитал хаус" ХХК гүйцэтгэж байгаад гэрээний үүргээ биелүүлээгүй учир 2017 онд гэрээг Эрүүл мэндийн яам цуцлан дахин тендер зарлаж "ЭСБА интернейшнл" ХХК 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн ЭМЯ-2017/XV1.5 дугаар гэрээгээр 1,695,422,642 төгрөгийн гэрээ байгуулан ажил гүйцэтгэж байна. 2017 онд 1,695,422,642 төгрөг тусгагдсанаас 1,495,322,659 төгрөгийн санхүүжилт аван 200,099,983 төгрөг татуулсан. 2018 онд ашиглалтад орсон.	100%
99		10. Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх тасгийн барилгыг ашиглалтад оруулах	2016 - 2018			Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх тасгийн барилгын ажлын хувьд барилга угсралтын ажлын явц 100%. Комисс ажиллахаар хүлээгдэж байна.	100%
100		11. Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын барилгын өргөтгөлийг барих	2018 - 2019			2020 оны Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын саналд Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын барилгын өргөтгөлийн санхүүжилт 1.8 тэрбум төгрөгөөр тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй.	Үнэлэх боломжгүй
101	3.1.18.Хөдөөгийн суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах	1. Орон нутагт, ялангуяа сумдын эрүүл мэндийн төвийн эмчийг тогтвор суурьшилтай ажиллаж амьдрахад нутгийн засаг захиргааны	2017 - 2020	-		2020 оны улсын төсөвт орон сууцны нэг маягийн зураг төсөл боловсруулах хөрөнгийг тусгах санал боловсруулан, Сангийн яаманд хүргүүлсэн. Орон сууцны нэг маягийн зураг төсөлтэй болсоноор хөдөөгийн суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлөөр хангах орон сууцтай болох нөхцөл бүрдэнэ. "150 000 айлын орон сууц" үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын 2019.05.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 202 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ хөтөлбөрт 2023	100%

	үүднээс хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар хангах асуудлыг дэмжинэ.	байгууллагаас дэмжлэг үзүүлэх, орон байраар хангах			оны түвшинд 30000 төрийн албан хаагчийг шинээр орон сууцтай болгох зорилт дэвшүүлсэн болно.  Хавсралт : 2 файл	
102	3.2.3.Анги дүүргэлт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, ээлжтэй сургуулийг ээлжид шилжүүлнэ.	хэт 3 2	2. Улаанбаатар хот, аймгийн төвд шинээр барих орон сууцны хороолол, хотхоны зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөнд цэцэрлэг, сургуулийг заавал тусгаж төлөвлөх чиглэлээр холбогдох норм, дүрэмд өөрчлөлт оруулж, тусгасан нөхцөлд газрын зөвшөөрлийг шийдвэрлэж байх зохицуулалтыг бий болгох	2017 - 2020	Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг "Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" (БНБД 30-01-04)-ийн дагуу Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж боловсруулдаг ба "Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" (БНБД 30-01-04)-ийн 5.4-т хот, тосгоны суурьшлын бүсэд цэцэрлэг 300 м, сургууль 500 м радиус тутамд төлөвлөхөөр тусгагдсан. Түүнчлэн хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тухайн орон нутаг буюу аймаг, нийслэлийн сум дүүргийн Засаг дарга хэрэгжүүлдэг. Иймд энэхүү зохицуулалт нь холбогдох хууль тогтоомж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм дүрэмд байгаа зохицуулалт юм. Улаанбаатар хотод сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах зорилгоор шинээр барих орон сууцны хороолол, хотхон болон конторын зориулалттай 9-өөс дээш давхар барилгын зураг төсөлд цэцэрлэг төлөвлөн тусгах талаар, зарим барилгыг цэцэрлэгийн зориулалтаар ашиглах зохицуулалт Засгийн газрын 2016 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан болно. Хавсралт : 2 файл	100%
103	3.2.23.Оюутны дотуур байрны хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ.		1. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын оюутны байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх	2017 - 2020	Улаанбаатар хотыг 2020, 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, төлөвлөгөөний тодотголд их, дээд сургуулийн оюутны байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх, оюутны хотхон байгуулах асуудлыг бүрэн тусгасан. Мөн аймаг, сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дээрх асуудлыг тусган батлуулаад байна.	70%
104	3.2.40.Сансрын холбооны үндэсний хиймэл дагуул төслийг хэрэгжүүлж, газар сансрыг холбосон үндэсний харилцаа холбооны сүлжээ		4. Хиймэл дагуулын хяналтын газрын станцын барилга барих	2019 - 2020	Харилцаа холбоо мэдээлэл технологийн газраас ирүүлсэн хүсэлт саналын дагуу тус яам хамтарч ажиллах ёстой. Одоогоор энэ талаар ямар нэгэн асуудал дэвшүүлсэн санал санаачлага ирүүлээгүй байна.	Үнэлэх боломжгүй

	байгуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаална.						
105	3.3.4.Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлнэ.	1. Барилгын салбарын эрэлтэд нийцсэн мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоог холбогдох байгууллагатай хамтран бүрдүүлэх	2017 - 2020			Барилгын салбарын эрэлтэд нийцсэн мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх ажлыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дэргэдэх Барилгын салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын зөвлөл хариуцан хэрэгжүүлж байна. Энэ зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг боловсруулж, Мэргэжил боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн 2019.02.01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулсан. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дэргэдэх Барилгын салбарын зөвлөлийн гишүүдийн чадавхи дээшлүүлэх уулзалт, хэлэлцүүлгийг ХНХЯ, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл, Европын холбооны "МОНГОЛ УЛСЫН ТМБССДТ-1" ТӨСӨЛ, МАОЭНХ хамтран 2019.02.29-03.01-ний өдрүүдэд зохион байгууллаа. 2019 оноос барилгын салбарын чиглэлээр мэргэжилтэй ажилчин бэлтгэж байгаа мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийг "Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл" болон "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх мэргэжлийн зөвлөл"-өөр хэлэлцүүлэн магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна. "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх мэргэжлийн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд БХБЯ-ны төлөөлөл оролцон ажиллаж байна. *Барилга, хот байгуулалтын сайдын 2019.04.22-ний өдрийн 79 дүгээр тушаалаар "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт" (YAMAT-08)-д тусгагдсан барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуй, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.	100%
106		2. Салбарын суурь судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх	2017 - 2020			*2019 онд барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгөөр "Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх" төслийн ажлыг эхлүүлээд байна. Энэ төслийн хүрээнд барилгын салбарын чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, түүний ажиллах хүч, мэргэжилтний судалгаа болон салбарын чиглэлээр суралцагсадын мэдээллийн санг бүрдүүлнэ.	100%

					<p>Барилгын салбарт ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 6947 аж ахуйн нэгжид 2018 оны байдлаар 76596 инженер-техникийн болон мэргэжилтэй ажилтан ажиллаж байна. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 590 аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрлийг шинээр болон сунгалт, нэмэлт заалтаар олгов. 2019 оны 2 дугаар улирлын байдлаар барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэх 10 аж ахуйн нэгж, байгууллага нь 735 гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах зөвшөөрлийг Засгийн газраар шийдвэрлүүлсэн. БХБЯ-ны харъяа Барилгын хөгжлийн төв /ТӨААТҮГ/-өөс "Барилгын салбарын инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын эрэлт, нийлүүлэлтийн судалгаа"-г жил бүр хийж, тайлан гаргаж байна. Үүнд: 2018-2019 оны хичээлийн жилд барилгын салбарын мэргэжлээр төрийн болон төрийн бус 20 их, дээд сургууль, коллежид 9875 оюутан, 47 мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад 24 мэргэжлээр 7135 суралцагч суралцаж байна. Барилгын салбарын мэргэжлийн чиглэлээр 2017-2018 оны хичээлийн жилд их, дээд сургуулийг 2813 оюутан, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн болон бусад сургалтын төвийг 4098 суралцагч суралцаж төгссөн байна. Хавсралт : 4 файл</p>	
107	3.3.8.Үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчнийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлнэ.	1.Барилгын салбарын мэргэжилтэй ажилчдыг үйлдвэрлэлийн баазад түшиглэн давтан сургах тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2020		<p>Монгол Улсад үйлдвэрлэлийн баазад түшиглэн давтан сургах тогтолцоог бүрдүүлэхийн тулд "Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш" бэлтгэх ажил маш чухлаар тавигдаж байгаатай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас төслийн хүрээнд 30 гаруй үндэсний сургагч багшийг бэлтгэсэн. *Барилга, хот байгуулалтын яамнаас боловсруулсан "Үйлдвэрлэлийн дадлагажуулагч бэлтгэх журам"-ын төслийг Өмнөговь, Дархан-Уул, Улаанбаатар, бүх яамдын төлөөллүүдээр хэлэлцүүлэн Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн. Засгийн газрын тогтоолоор уг журмыг батлуулахаар ажиллаж байна. Мэргэжлийн зөвлөлийн 2 удаагийн хуралд оролцож, мэргэжлийн боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх дүгнэлтийг гаргасан.</p> <p>Мэргэжлийн боловсрол, сургалтын Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах хөтөлбөр"-төсөлтэй танилцаж, холбогдох саналыг бэлтгэн 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 05/2077 тоот албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлэв. Мэргэжлийн боловсрол, сургалтын</p>	100%

					Үндэсний зөвлөлтэй хамтран Барилгын салбарын зөвлөлийн гишүүд болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлд зориулсан сургалт-семинарыг 2019.06.27-ны өдөр Улаанбаатар зочид буудалд зохион байгуулсан. Барилгын салбар зөвлөлийн дэргэд Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын болон Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2 дэд зөвлөлийг байгуулах саналыг боловсруулаад байна.	
108	3.3.9.Мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	1. Мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд болон барилгын салбарын хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх	2017 - 2020		Барилгын салбарын мэргэжилтэй ажилчин бэлтгэдэг 47 МСҮТ-д 2018-2019 оны хичээлийн жилд суралцаж байгаа 7135 суралцагч нь суралцах хугацаандаа барилгын салбарын хувийн хэвшлийн байгууллагууд дээр үйлдвэрлэлийн дадлага сургалтыг жил бүр хийж байна. БХБЯ-наас Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг(GIZ)-тэй хамтран Монгол Улс, ХБНГУ-ын хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааны түншлэлийг хөгжүүлэх төслийг 2019-2021 онуудад хэрэгжүүлэхээр тохиролцоод байна. Уг төслийн концепцийг 2019 оны 5 дугаар 27-ны өдөр Германы Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ)-наас зөвшөөрч баталсан бөгөөд Монгол Улсын барилгын салбарын хувийн хэвшлийн 5 аж ахуйн нэгж, ХБНГУ-ын 3 аж ахуйн нэгжүүд хамтран оролцож ажиллана. Барилга, хот байгуулалтын яамнаас Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институттэй хамтран барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох судалгааны ажлыг зохион байгуулж байна. 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр “Барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох судалгаа”-г зохион байгуулах уулзалтыг хийсэн. Одоогийн байдлаар нийслэл болон аймгуудад зохион байгуулсан сургалтуудад барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй нийт 170 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл хамрагдаад байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын вэб хуудсаар дамжуулан цахим асуулгын аргаар аж ахуй нэгжийн хүний нөөцийн мэргэжилтэн, захирал эсвэл холбогдох мэргэжилтнүүдээс мэдээллийг цуглуулж боловсруулж байна. <a href="http://rilsp.gov.mn/barilga/">http://rilsp.gov.mn/barilga/</a> Дээрх мэдээлэлд үндэслэн төслийн гүйцэтгэгчээс барилгын салбарын эрэлтийн судалгааны тайлангийн эхний хувилбарыг боловсруулсан. Энэ тайлангийн эхний хувилбарыг 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр БХБЯ, ХНХЯ болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт /GIZ/ танилцуулсан.	100%

109		1. Хот төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах арга хэмжээг тусган боловсронгуй болгох	2017 - 2020		Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийн асуудал тусгагдаж хуулийн үзэл баримтлалын төсөлд "Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах нөхцлийг хангасан төлөвлөлтийг тусгаж хэрэгжүүлэх..." гэж тусгасан болно. Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Барилга, хот байгуулалтын сайдаар 2019.02.14-ний өдөр батлуулсан. Хавсралт : 1 файл	100%
110	3.3.28.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.	2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах талаар хот, суурины хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төсөл, барилга байгууламжийн зураг төсөлд тусгуулан хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	2017 - 2020		Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах зургийн даалгаварт Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах талаар тогтмол тусган Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулдаг. 2017 онд Ховд, Дорнод, Багануур, Дундговь аймгуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлагдсан зургийн даалгаврын хүрээнд боловсруулан ЗГ-ын 2017 оны 347 дугаар тогтоолоор Ховд, Дорнод, Багануурын, Дундговь аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг АИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар тус тус баталсан. 2018 онд Архангай, Өвөрхангай, Хэнтий, Завхан аймгуудын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах зургийн даалгаварт тус арга хэмжээний талаар тусган БХБ-ын сайдаар батлуулж, батлагдсан зургийн даалгаврын хүрээнд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж байна. ХНХ-ын сайдын 2018.04.08-ны өдрийн А/144 тоот тушаалаар байгуулсан БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор" барих төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнд ажиллаж, 2019.04.11, 2019.04.16-ны өдрүүдэд зохион байгуулсан Удирдах хорооны хуралд оролцон Хятадын талын холбогдох хүмүүст барилга, хот байгуулалтын холбогдолтой мэдээ, мэдээлэл болон зөвлөмж чиглэлийг өгсөн. Хавсралт : 1 файл	70%
111		5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх	2017 - 2020		Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг баталсан. БХБЯ-наас уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2018-2022 он/-ний дагуу дараах ажлуудыг хийж байна. Үүнд: "150 мянган айлын орон сууц" үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 202 дугаар тогтоолоор	100%

					батлуулсан. Уг хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг түрээсийн болон халамжийн орон сууцанд хамруулахаар тусгасан. “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ыг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 138 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн түрээсэлж буй орон сууцаа тодорхой нөхцөлийн үндсэн дээр худалдан авч, өмчлөх, түүнчлэн ипотекийн зээлд хамрагдах боломжийг бүрдүүлсэн. “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-г шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 106 дугаар тогтоолоор батлуулсан. Хавсралт : 2 файл	
112	3.3.29.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна.	1. Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх	2017 - 2020		Барилга, хот байгуулалтын яам болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачлан Монгол Улсад анх удаа харааны бэрхшээлтэй хүүхэд багачууд, сурагчдад зориулсан 4 төрлийн брайль газрын зургийг/ дэлхийн газрын зураг, Монгол орны засаг захиргааны зураг, 116-р сургууль орчмын тойм зураг, сургуулийн хашаан доторх тойм зураг гэсэн төрлөөр/ зохион хэвлүүлж 2019 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар тусгай дунд сургуульд хүлээлгэн өгч суралцах орчныг бүрдүүлж, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Хавсралт : 1 файл	100%
113	3.4.3.Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг арга хэмжээг үе	3.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд залуу гэр бүлийг орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулах журам боловсруулан хэрэгжүүлэх	2017 - 2018		"Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ын төслийг боловсруулж 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын 138 дугаар тогтоолоор батлуулсан. Ингэсэнээр түрээсийн орон сууцанд хамрагдсан залуу гэр бүл түрээслэж буй тухайн орон сууцныхаа нийт өртгийн 30 хувийг сар бүр төлөх төлбөрт ноогдуулан төлсний дараа ипотекийн зээлд хамрагдаж өмчлөх эрх нь бүрдсэн. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх дараах мэдээллийг 2019.11.12-ны өдрийн 03/4255 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.  Хавсралт : 2 файл	100%



114	шаттай нэвтрүүлнэ.	4. "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 20,000 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх	2017 - 2020	-	Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын "Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 2018 оны 81 дүгээр тогтоолыг баталсан. Хөгжлийн банкинд шилжүүлсэн 1542 айлын орон сууцанд иргэдийн хамруулах зорилгоор "Түрээсийн орон сууцны санд шилжүүлэх тухай" Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоолыг батлуулсан. Уг тогтоолоор Улаанбаатар хотод 972, Орхон аймагт 315, Хөвсгөл аймагт 135, Говь-Алтай аймагт 120 айлын түрээсийн орон сууцны санг тус бүр бүрдүүлж, иргэдийг бүртгэн оруулах ажлыг зохион байгуулсан. Мөн түрээслэн амьдарч буй орон сууцаа өмчилж авах боломжийг бүрдүүлэх зорилгоор "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ыг Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлуулсан. Уг журам батлагдсанаар иргэд өөрсдийн түрээсэлж буй орон сууцыг тухайн орон сууцны эзэмшигчтэй тохиролцон гэрээ байгуулсны үндсэн дээр 5 хүртэл жилийн хугацаанд нийт төлбөр, эсхүл урьдчилгаа төлбөрийг бүрдүүлж ипотекийн зээлд хамрагдах боломжтой болсон. 2019 оны жилийн эцсийн байдлаар дотоодын хөрөнгө оруулалт, зээлээр улсын хэмжээнд нийт 3054 айлын төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдээд байна. Мөн агаар, орчны бохирдлыг бууруулах, түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт "Ногоон нуур - 1008 айлын орон сууц" төсөл, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлттэй зээлээр нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт "Солонго -1", "Солонго - 2" 5002 айлын орон сууцны төсөл, Сонгинохайрхан нутаг дэвсгэрт "Баянголын ам" 2000 айлын орон сууцны төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. Дээрх төслүүд хэрэгжсэнээр төрийн болон орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны санг 8010 айлаар нэмэгдүүлж, зорилтод бүлгийн иргэдийн орон сууцанд хамруулах нөхцөлийг бүрдүүлээд байна. Хавсралт : 2 файл	100%
<b>Дөрөв. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>						
115	4.1.1.Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт	6. Ногоон барилгын үнэлгээний систем, аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх	2016 - 2020	-	Ногоон барилга, хот төлөвлөлтийн чиглэлээр Барилгын норм, нормативын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах баримт бичгүүдийг тусгаж шинээр болон шинэчлэн боловсруулж байна. Үүнд: -Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт; -Барилгын дулаан хамгаалалт /БНБД 23-02-09/ барилгын норм ба дүрэм; - Ногоон хот төлөвлөлтийн стандарт; -Ногоон барилга байгууламжид	100%

	технологи нэвтрүүлж, нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.				тавигдах шаардлага зэргийг тусган, боловсруулах ажлыг эхлүүлсэн. Ногоон барилгын үнэлгээний систем, аргачлал БД-ийн техникийн даалгаврыг боловсруулж дуусаад Архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.	
116	7."Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх	2016 - 2020	-		"Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, орон нутгийн барилгын материалын лабораториуд, барилгын материалын үйлдвэрүүдийн үйл ажиллагааг бодлого, зөвлөмжөөр хангаж ажиллах зорилтын хүрээнд орон нутгийн лабораториудыг итгэмжлүүлэх, мэргэжилтнүүдийг давтан сургах ажлыг СХГазартай хамтран зохион байгуулж байна. Барилгын материалын чанар аюулгүй байдлыг сайжруулах, зах зээлд худалдаалагдаж байгаа материалд хяналт тавих чиглэлээр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран 2 удаа улирлын хяналт шалгалт хийж, тайланг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Улаанбаатар хотын Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн цалин, урсгал зардал, тоног төхөөрөмжийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт суулгах жил бүр 750,000 сая төгрөг, бүсийн тулгуур төвүүдэл байгуулах 8 төрлийн лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн эх үүсвэр 340,000 сая, аймаг бүрт байгуулах 5 төрлийн лабораторийн 150,000 сая нийт 1.240,000 төгрөгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусган, төв болон орон нутгийн барилгын материалын лабораторийн төрлийг нэмэгдүүлэн өргөжүүлэх шаардлагатай байна. 21 аймгийн барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр 2020 оны улсын төсөвт 8 тэрбум төгрөг тусгуулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөвт тусгаадаагүй.	70%
117	4.1.2.Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, нүүрсхэрэглээний халуун боловсруулж усны хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангах загвар төслүүдийг хийн хэрэгжүүлэх	2017 - 2020			Улаанбаатар хотын захын бүсийн гэр хорооллын айл өрхийн хэрэглээний халуун ус, цахилгааны хэрэглээг сэргээгдэх эрчим хүчээр хангах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар БЗД, ХУД-ийн 62 өрхийн гадна, дотор гэрэлтүүлэгт нарны зайн панел суурилуулж, сэргээгдэх эрчим хүчээр гэрэлтүүлэх мөн цахилгаан халаагуурыг нийслэлийн 200 гаруй өрхөд, төвийн шугамд холбогдоогүй хороо, өрхийн эмнэлгийн 5 байранд цахилгаан халаагуурыг тус тус суурилуулсан. Өмнөд, өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд гадны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил: Улаанбаатар хотын захын бүсийн гэр хорооллын эрчим хүчний хүрэлцээ муу, эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдэд сэргээгдэх	70%

	<p>үйлдвэрлэл, бизнесийг олон улсын хамтын ажиллагааны хүрээний дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.</p>				<p>/нарны/ эрчим хүчний үйлдвэрлэлийг нутагшуулах, суурьшуулах ажлыг БНСУ-ын тусламжаар нийслэлтэй хамтран загвар төсөл хэрэгжүүлэх БЗД-ийн 10 айл сонгон авч, хэрэглээний халуун ус, цахилгааны хэрэглээг сэргээгдэх эрчим хүчээр хангах туршилтыг хийж гүйцэтгэсэн. Уг зорилтын хүрээнд дээрх төсөл, арга хэмжээний эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбар хоорондын бодлого, үйл ажиллагааны уялдааг хангах, үндэсний хөтөлбөрт туссан салбарын чиг үүрэгтэй холбоотой ажлыг зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах чиг үүрэг бүхий Эрчим хүчний Сайдын 2018 оны 89 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж салбарын чиглэлээр хийгдэх зорилт, арга хэмжээний санал өгч, тусгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭХЯ, Эрчим хүчний зохицуулах хорооноос 2019.04.18, 2019.04.30, 2019.11.17-ны өдөр зохион байгуулсан салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах зөвлөлдөх уулзалт болон Ажлын хэсгийн хуралд оролцож, хийгдэж буй ажлын талаар хэлэлцсэн болно. Хавсралт : 1 файл</p>	
118	<p>4.1.6.Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</p>	<p>5. Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх</p>	2016 - 2020	<p>10,0 тэр.төг - Нийслэлийн төсөв, 330,0 сая төг.- Улсын төсөв 11,5 сая ам.доллар - АХБ, ЕХОБ, НЗДТГ</p>	<p>Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх төсөл БОАЖЯ-нд хэрэгжиж байна. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн төсөл болон Шинэ бүтээн байгуулалт зорилтот хөтөлбөрт төвлөрсөн сүлжээнд холбогдох боломжгүй айл өрхөд шаардлага хангасан сайжруулсан нүхэн жорлон суурилуулахаар тусгасан. Ингэснээр УБ хотод нийт өрхийн 10 хувь, орон нутагт 60 хувийг холбохоор тусгаж санал хүргүүлсэн. УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд шаардагдах хөрөнгөнд АХБ, ЕХОБ, НЗДТГ-аас 2019 онд 11.5 сая.ам.долларын санхүүжилт олгосон. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, авто зам, нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын барилга угсралтын нийт ажлын явц 2019.12.10-ний байдлаар 80%-ийн гүйцэтгэлтэй байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны төсвийн багцад нийслэлийн Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд “Бичил дэд төв”-ийг барих санхүүжилтийг тусган батлуулж, эхний ээлжийн газар чөлөөлөлт, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 25 хувийн гүйцэтгэлтэй, 330.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулаад байна. Мөн нийслэлийн 2018 оны төсвийн 10.0 тэрбум</p>	100%

					төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Бичил дэд төв”-ийн ус, дулаан хангамж, нам даралтын халаалтын зуух, авто зам, гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж, 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ашиглалтад оруулсан. Хавсралт : 2 файл	
119		6. Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага MNS 5924:2015 стандартыг хэрэгжүүлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2017 - 2020		Барилга, хот байгуулалтын сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2019 онд байгуулсан гэрээний хавсралтад гэр хорооллын айл өрхүүдэд хөрсөнд нэвчдэггүй жорлонтой байх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх ажлыг тусган ажиллаж байна. АХБ-ны техник туслалцааны ТА9100-МОН төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн төв Арвайхээрт хөрсөнд нэвчдэггүй сайжруулсан нүхэн жорлон шинээр барьж, хүлээлгэн өгсөн. Төслийн үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн удирлагаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019.07.01-ний өдрийн А/106 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. МУИС-ын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зөвлөх баг Лагийг дахин ашиглан шахмал түлш, хөрс сайжруулагч үйлдвэрлэх зорилгоор дараах туршилт, судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: а/. УБ хотын Биокомбинатын цэвэрлэх байгууламжийн дэргэд хүлэмж байгуулан хөрс сийрэгжүүлэгч гарган авах туршилт;. б/. Өвөрхангай аймгийн төв Арвайхээрт сайжруулсан нүхэн жорлонтой айл, өрхөөс лагийн дээж авч лабораторид тодорхойлох судалгаа, шинжилгээний ажлууд;. в/. УБ хотын Биокомбинат болон Өвөрхангай, Архангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн лагийн шинж чанарыг судлан шахмал түлш гарган авах туршилтыг лабораторийн нөхцөлд туршсан. Дээрх туршилтуудад үндэслэн лагийг суллах, тээвэрлэх журам, стандартын төслийг боловсруулаад байна. Хавсралт : 3 файл	100%
120	4.2.3.Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи	3. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх	2017 - 2020	637,2 сая. төг Улсын төсөв	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг эхлүүлж, 17,6 га талбайд баригдах шинэ цэвэрлэх байгууламжийн зураг төслийг Шанхайн зураг төслийн хүрээлэнд боловсруулж, 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ЭЗ-5/2019 тоот ерөнхий дүгнэлтээр магадлал хийлгэн баталгаажуулсан. Цахилгаан хангамжийн 45/2019, дулаан хангамжийн 145с/2019/87, холбоо дохиоллын ТН-В546/2019 тоот техникийн нөхцөлүүдийн сунгалт хийгдсэн. Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэн батлуулсан. Цэвэрлэх байгууламжийн барилгын ажилд хэрэглэгдэх 120м3/цаг хүчин чадалтай бетон зуурмагийн 2 узелийг угсарч, БМУ-БЭ-376/2019 тоот технологийн зааврыг батлуулсан. Узелийн машин механизм, тоног	40%

	нэвтрүүлэхийг дэмжинэ.				төхөөрөмжүүдийг шалгаж, МХЕГ-ын №18000000104 тоот аюулгүй ажиллагааны гэрчилгээгээр баталгаажуулсан. Барилга байгууламжийн ажил эхлүүлэх 01/2019 тоот зөвшөөрөл авсан. Зөвшөөрлийн дагуу төслийн барилга угсралтын талбайн бэлтгэл ажлыг хангаж түр ажилчдын байр, хашаа, цамхагт краныг байршуулан, биологи цэвэрлэгээний байгууламжийн суурийн газар шорооны ажил, бетон зуурмагын узель угсрах, байгууламжийн суурийн ул бетон цутгах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Төслийн нийт төсөвт өртөг 262,7 сая.ам. доллар. Хавсралт : 3 файл	
121	4.2.5.Нийслэл, хот суурин газрын ундны эх үүсвэрийг хамгаалах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1. Гадаргын усыг хуримтлуулах замаар хот суурины хүн амын ус хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2017 - 2020	10,7 сая евро Гадаад эх үүсвэр	Гадаргын усыг хуримтлуулах "Туул усан цогцолбор" төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгах санал жил бүр хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Мөн АНУ-ын Мянганы сорилтын сангийн хөрөнгө оруулалтад тусгах санал хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан 40 сая еврогийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд 14 сая еврогийн Австрийн хөнгөлттэй зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Тайшир-Алтай ус хангамж" төслийн хүрээнд Австри Улсын "Тиролер Рохре" ХХК-тай "Зураг төсөл-нийлүүлэлт-барилга угсралт"-ын ажлын гэрээ байгуулан ажиллаж байна. Барилга байгууламжийн зураг төслийн ажил 100 хувь дуусч, 2019 оны 4 дүгээр сарын 1-ны өдрийн 408/2019 дугаартай магадлалын дүгнэлт гарсан. Барилгын ажил 2019 оны 04 дүгээр сараас эхэлсэн. Төслийн хүрээнд 54 км ган хоолой угсрахаас 27 км хоолойг угсарсан. Ус цэвэршүүлэх станц, усан сан, өргөлтийн насос станц болон 14 метрийн гүнтэй ус авах цооногийн төмөр бетон цутгалтын ажил тус тус бүрэн дууссан. Нийт барилга байгууламжийн угсралтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт : 1 файл	70%
122		2. Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, усыг хэмнэлттэй зарцуулах хэвшлийг бий болгох	2017 - 2020		Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөлийн судалгаагаар салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 147 байгууллагын түвшинд тоолууржилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 84,4 хувь байна. "Дэд бүтэц-ухаалаг шийдэл" туршилтын төслийн хүрээнд ОХУ-ын "Арзамас" үйлдвэрт үйлдвэрлэсэн 2000 гаруй ухаалаг тоолуурыг Улаанбаатар, Дархан хотын ОСНААБ-дад нийлүүлж, суурилуулсан. Ховд аймгийн "Шим ус" ОНӨААТҮГ, Баянхонгор аймгийн "Чандмань Баянхонгор" ХК, Налайх Дүүргийн "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын	100%

					тоолууржилтын байдалд хяналт хийж, тоолууржилтыг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган ажиллах чиглэл өгсөн. Хавсралт : 1 файл	
123		3. Хот, суурины инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд хүрэх мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах	2016 - 2020	1,7 тэрбум төгрөг - Улсын төсөв	“Улаанбаатар хотын газар дээрх болон доорх инженерийн шугам сүлжээний зураглал хийх” ажлын хүрээнд яамтай байгуулсан гэрээний дагуу нийслэлийн 9 дүүрэгт “Топсүрвэй”, “Геомастер”, “Эй Эс Эм” ХХК-ийн түншлэл газар дээрх болон доорхи инженерийн шугам сүлжээний зураглалын ажлыг бүрэн гүйцэтгэж, мөн “Инженер геодези” ХХК захиалагчийн техникийн хяналт хийж, 2017.08.23-ны өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд ажлын гүйцэтгэл 100% гэж дүгнэсэн. Мөн уг төслийн хүрээнд “Улаанбаатар хотын барилгажсан талбайн 1:5000, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн 1:10000 масштабтай газар хөдлөлийн бичил мужлалын зураг хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “ШУА-ийн Одон орон геофизикийн судалгааны төв” шалгарч, ажлыг бүрэн дуусгасан бөгөөд захиалагчийн зүгээс ГЗБГЗЗГ гэрээг дүгнэж, эцсийн тайланг хянаж, мэдээллийн санд оруулсан. Мөн ГЗБГЗЗГ-аас “Геоценоз”, “Бориг тэс” ХХК-уудын ирүүлсэн гүйцэтгэлд захиалагчийн хяналт хийж, 19 аймгийн геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран газар дээр нь тулгалт хийж, газар дээрх, доорх шугам сүлжээний зураглал бүрэн хийж дууссан. “Улаанбаатар хотын бүсчлэлийн төлөвлөлт, инженер-геологийн судалгаа, газар хөдлөлтийн болон газар дээрх, доорх зураглал хийж, мэдээллийн сан үүсгэх” /ХБГХ-2012-07/ төслийн хүрээнд нийт 5 багц ажлыг хийж дууссан бөгөөд захиалагчаас эцсийн тайланг хянаж, актаар хүлээн авсан. ГЗБГЗЗГ актаар хүлээж авсан дээрх 5 багц ажлыг мэдээллийн санд бүрэн оруулахад захиалагчийн зүгээс чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан. “Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журам”-ыг 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайдын 74 дугаар тушаалаар батлуулав.	100%
124	4.2.6.Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд	2. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2016 - 2020	-	"Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэгч үндсэн хариуцагч БОАЖЯ-с хөтөлбөрийг батлуулаагүй байна.	Үнэлэх боломжгүй

орсон нутгийг сэргээнэ.	газар нөхөн						
<b>ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
125	5.1.3.Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж байгаа бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ.	2. Төрөөс барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах	2016 - 2017	-		"Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн талаар цаашид баримтлах бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тусган Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор батлуулсан. Түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БХБСайдын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 67 дугаар тушаалаар батлуулсан. Дээрхи бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг яамны 2019 оны сүүлийн хагас жилийн болон 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Хавсралт : 2 файл	100%
126	5.1.7.Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.	2. Барилга, хот байгуулалтын салбарын жендэрийн хөтөлбөр боловсруулж, батлуулах	2016 - 2017	-		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг боловсруулан, Хүний эрхийн үндэсний комисст Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03/897 тоот албан бичгээр хүргүүлэв. Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн “Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт ба сургамж” тайлан, зөвлөмжтэй танилцаж, саналыг 2019 оны 05/1197 тоот албан бичгээр хүргүүлэв. Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн талаар Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03/4050 тоот албан бичгийг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэв. Жендэрийн үндэсний хорооноос бэлтгэн ирүүлсэн “Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж” тайлан /англи, монгол хэлээр боловсруулсан./-г ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК-д 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 03/1769 тоот албан бичгээр тус тус хүргүүлж үйл ажиллагаанд нь ашиглуулж байна. - ХНХЯ-наас 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Хүний эрхийн төлөө” төр-нийгмийн талуудын уулзалтад оролцов. - БХБЯ-ны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу удирдах албан хаагчдын жендэрийн цахим сургалтад хамруулах тухай 2019 оны 03/4427 тоот албан бичгийг ГЗБГЗЗГ, БХТ, ТОСК, 21 аймгийн	100%

					ГХБХБГ-т хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан. Хавсралт : 1 файл	
127	5.1.12.Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, нөхцөлийг сайжруулах бодлого баримтална.	1. Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөр баталж, орон сууцаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх	2017 - 2020		150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан. Энэхүү төсөлд 2023 оны түвшинд 30000 төрийн албан хаагчийг шинээр орон сууцтай болгох зорилтыг дэвшүүлсэн. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, БХБС-ын 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 125 дугаар тушаалаар батлуулж, холбогдох байгууллагуудад яамны 2019.07.16-ны өдрийн 03/2786 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар яамны 2019.09.18-ны өдрийн 01/3550 тоот албан бичгээр холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Хавсралт : 2 файл	100%
128	5.1.21.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.	1. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу бүх аймгийн төв болон 15,000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг боловсруулах	2017 - 2018		Тандан судалгаагаар гарсан зөвлөмжийн дагуу УИХ-аас Монгол Улсын Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах, "Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулахтай холбогдуулан уг төслийн хүрээнд Дархан, Эрдэнэт, Чойр гэсэн улсын зэрэглэлтэй хотоос Чойр хотыг хасч, бүсийн тулгуур төв болон хүн амын тоо, өсөлт, нийгэм-эдийн засгийн таталцал, хөгжлийн нөөц, чадавхи, стратегийн ач холбогдол зэргийг харгалзан Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Ховд, Мөрөн, Замын-Үүд хотыг улсын зэрэглэлтэй, үлдэх 16 аймгийн төв болон Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Хөтөл, Хөвсгөл аймгийн Хатгал, Өвөрхангай аймгийн Хархорин, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Завхан аймгийн Тосонцэнгэл, Ховд аймгийн Булган Дархан-Уул аймгийн Шарын гол, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдыг аймгийн зэрэглэлтэй хотоор тодорхойлох хувилбарын тооцоолол, судалгааг боловсруулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтоох, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ гэж заасны дагуу удирдлагын давхардлыг арилгаж, хотуудын засаглалын эрх мэдэл нэмэгдэх боломжтой болсон. Хавсралт : 2 файл	100%
129	5.2.4.Газрын харилцааны эрх	1. Олон улсын стандартад нийцсэн	2016 - 2017	-	Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд болох Швед, Орос, Герман зэрэг 30 гаруй улсад хэрэглэж буй газрын төлбөр, татварын	100%



	зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлнэ	газрын эдийн засгийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, батлах				зориулалттай газрын суурь үнэлгээг төрөөс тогтооход ашигладаг кадастрын масс үнэлгээний аргыг үндэслэн газрын зах зээлийн бодит үнэ, эрэлт хэрэгцээ, газар ашиглалтын зориулалт, газрын үр өгөөж, байршил зэрэгт нийцүүлэн газрын төлбөр, татварын зориулалттай суурь үнэлгээг тогтооход хэрэглэх нэгдсэн арга зүй, газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, Засгийн газрын "Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал батлах тухай" 2018 оны 181 дүгээр тогтоолоор батлуулсан. Хавсралт : 1 файл	
130		2. Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох	2016 - 2018	850,0 сая төг		"Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох" ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Эцсийн шатны тайланг хүлээн авч акт үйлдэн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/4897 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	100%
131		3. Газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар ханган, эдийн засгийг эрчимжүүлэх	2016 - 2018	698,0 сая төг		Газрын цахим биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар хангах эдийн засгийг эрчимжүүлэх" ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг боловсруулж, батлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Эцсийн шатны тайланг хүлээн авч акт үйлдэн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/4898 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	100%
132		4. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголтой нийцүүлж газар ашиглалтын зориулалт бүрээр газрын тохиромжтой	2016 - 2020			Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлуулсан. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусган ажиллаж, удирдах ажилтны зөвлөгөөн болон аймаг, нийслэлийн Газрын албадын дарга нарын удирдах ажилтны зөвлөгөөнд чиглэл зөвлөмж өгч ажилласан. Мөн Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлагдсантай холбогдуулан 21 аймгийн Засаг дарга, ГХБХБГ-ын удирдлагуудад танилцуулж санал солилцох ажлыг ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан. Улсын газар зохион байгуулалтын	100%

		байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох			ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2019.05.06-ны өдрийн 01/1607 тоот албан бичгээр хүргүүлж, уг төлөвлөгөөг Ерөнхий сайдын захирамжаар батлуулах ажлыг зохион байгуулж байна. 2017-2019 онд Орхон, Төв, Дундговь, Завхан, Дорнод, Увс, Хөвсгөл, Өмнөговь, Говьсүмбэр аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж, батлуулсан. Хавсралт : 1 файл	
133		5. Мэдлэгт суурилсан газар зохион байгуулалтын төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор ил тод хийж, тэдгээрийг орон нутагтаа баялаг бүтээх боломжийг бүрдүүлэн, олон төрөлтөт эдийн засгийн хөгжлийн үндсийг бий болгох	2016 - 2020		Мэдлэгт суурилсан газар зохион байгуулалтын төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор ил тод хийж, тэдгээрийг орон нутагтаа баялаг бүтээх боломжийг бүрдүүлэн олон төрөлтөт эдийн засгийн хөгжлийн үндсийг бий болгох техникийн төсөл /ТЭЗҮ/-ийг боловсруулж, Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2017.03.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг 2017.05.29-ний өдөр БХБ-ын дэд сайдаар батлуулсан. 2017 онд Ховд аймгийн Мянгад, Говь-Алтай аймгийн Халиун, Өмнөговь аймгийн Цогцэций, Баян-Овоо, Ханбогд, Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Дорноговь аймгийн Өргөн сумдууд нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулсан. Мөн Говь-Алтай аймгийн Халиун сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах ажлыг сайжруулах, зөвлөмж өгөх ажлыг 2018 оны 10 сард аймгийн ГХБХБГ, сумын Газрын даамалтай хамтран зохион байгуулан ажилласан. Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах эцсийн шатны тайланг шалгаж, хяналт хийж, дүгнэлт зөвлөмжийг 2017.12.07-ны өдрийн 1/2316, 1/2317, 1/2326 тоот албан бичгүүдээр гүйцэтгэгч компани болон Өмнөговь аймгийн ГХБХБГ-т тус тус хүргүүлсэн. 2018 оны байдлаар Завхан аймгийн Цэцэн-уул, Отгон сум, Ховд аймгийн Мянгад, Говь-Алтай аймгийн Халиун, Өмнөговь аймгийн Цогцэций, Баян-Овоо, Ханбогд, Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Дорноговь аймгийн Өргөн, Говьсүмбэр аймгийн Баянтал, Сүмбэр, Шивээговь сумдууд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хүлээн авсан. 2017-2019 онуудад Архангай аймгийн 1 сум, Булган аймгийн 1 сум, Говь-Алтай аймгийн 1 сум, Говьсүмбэр аймгийн 3 сум, Дорнод аймгийн 1 сум, Дундговь аймгийн 15 сум, Дорноговь аймгийн 1 сум, Завхан аймгийн 1 сум, Орхон аймгийн 1 сум, Өмнөговь аймгийн 3 сум, Увс аймгийн 4 сум,	100%

					Ховд аймгийн 6 сум, Хэнтий аймгийн 4 сум тус тус нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хийж хүлээн аваад байна.	
134		6. Байрлалд суурилсан нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан, системийг улсын хэмжээнд бий болгож, эрүүл мэнд, боловсрол болон бусад байгууллагуудыг ашиглах боломжоор хангаж, тогтолцоог бүрдүүлэх	2016 - 2020		Байрлалд суурилсан, байнга шинэчлэгдэж байдаг нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан, системийг улсын хэмжээнд бий болгож эрүүл мэнд, боловсрол, төлөвлөлтийн байгууллагуудыг ашиглах боломжоор хангаж, тогтолцоог бүрдүүлэх техникийн төсөл /ТЭЗҮ/-ийг боловсруулж, 2017.05.29-ний өдөр БХБ-ын дэд сайдаар батлуулсан. Нийгэм, эдийн засгийн мэдээллийн санг ажиллуулах, хөтлөх журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ГЗБГЗЗГ-ын даргын 2017.03.16-ны өдрийн А/74 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн уулзалтыг 2017.04.10-ны өдөр зохион байгуулж, НЭЗМС-ийн талаарх танилцуулга болон журмын төслийн анхны хувилбарыг танилцуулсан. Нийгэм, эдийн засгийн мэдээллийн санг цаашид ажиллуулах, хөтлөх системийн инженерүүдэд зориулсан сургалтыг 2017.03.24-ний өдөр ГЗБГЗЗГ-ын ОЗМТХ болон ГЗБХ-ийн мэргэжилтнүүдэд гүйцэтгэгч компанийн зүгээс хийх ажлыг зохион байгуулсан. НЭЗМ-ийн санг бүрдүүлэх ажлын эцсийн шатны тайланд дүгнэлт гаргах, мэдээллийн санг туршиж хүлээж авах үүрэг бүхий Ажлын хэсгийг ГЗБГЗЗГ-ын даргын 2017.05.31-ний өдрийн А/161 тоот тушаалаар байгуулсан. Байрлалд суурилсан, байнга шинэчлэгдэж байдаг нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан, системийг улсын хэмжээнд бий болгож эрүүл мэнд, боловсрол, төлөвлөлтийн байгууллагуудыг ашиглах боломжоор хангаж, тогтолцоог бүрдүүлэх техникийн төсөл /ТЭЗҮ/-ийг боловсруулан ГЗБГЗЗГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2018 оны улсын төсөвт тусгагдаагүй болно. Иймээс 2020 оны улсын төсөвт уг ажилд шаардагдах зардлыг тусгуулахаар ажиллаж байна. Засгийн газрын 2018.12.19-ний өдрийн хуралдаанаар Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дагуу Байрлалд суурилсан, байнга шинэчлэгдэж байдаг нийгэм, эдийн засгийн нэгдсэн мэдээллийн сан, системийг улсын хэмжээнд бий болгож эрүүл мэнд, боловсрол, төлөвлөлтийн байгууллагуудыг ашиглах боломжоор хангаж, тогтолцоог бүрдүүлэх мэдээлэл батлагдсан.	Үнэлэх боломжгүй
135	5.2.11.Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг	1. Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн	2016 - 2018		Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2019.03.26-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг тайлан, судалгааны хамт боловсруулж, холбогдох зөвшөөрлийг авч, яамны 2019.10.03-	100%

	илрүүлэх, арилгах, шинэ хуулийн төсөл боловсруулахад эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах замаар хууль, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог дээшлүүлнэ.	төслийг боловсруулах			ны өдрийн 01/3727 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 46 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусган эцэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Үүний дагуу саналыг тусган, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайдаас холбогдох зөвшөөрлийг авч, төслийн бүрдүүлбэрийг хангаж, 2019.12.02-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хавсралт : 4 файл	
136		2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	2016 - 2019		Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хүрээнд хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Барилга, хот байгуулалтын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд 2019.05.10-ны өдөр батлуулсан. Хуулийн давхардал, зөрчил, хийдлийн талаарх судалгааны, гадаад орнуудын туршлагаас харьцуулсан тандан судалгааны болон хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хуулийн төслийг салбарын удирдах ажилтны түвшинд 2019.03.26, 2019.10.29-ний өдрүүдэд зохион байгуулсан зөвлөгөөнд хэлэлцүүлж санал авч, хуулийн төсөлд тусгасан. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хавсралт : 1 файл	100%
137		3. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах	2016 - 2018		Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, бүх яамд, аймаг нийслэлийн ЗДТГ, ТББ-аас санал авсан. Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2019.10.09-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 60 гаруй мэргэжилтэн оролцож санал өгсөн. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг 2019.10.16-ны өдөр хуралдуулж, эцсийн санал авч боловсруулсан. Хуулийн төслийг БХБ-ын Сайдын Зөвлөлийн хуралдаанаар 2019.10.22-ны өдөр хэлэлцүүлсэн. Зөвлөлийн гишүүдээс гарсан саналуудыг тусган, хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4131 тоот албан бичгээр, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2019.11.05-ны өдрийн 01/4132 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-ны 2019.12.16-ны өдрийн 6/8231, ХЗДХЯ-ны 2019.12.16-ны өдрийн 1-1/5545 тоот албан бичгээр хүлээн авч, ЗГХЭГ-т 2019.12.17-	100%

					ны өдрийн 01/4676 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. УИХ-аар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ-аас 2019.12.30-ны өдрийн 6/8616, ХЗДХЯ-ны 1-1/5796 тоот албан бичгээр тус тус авч, ЗГХЭГ-аас 2019.12.31-ний өдөр УИХ-ын Тамгын газарт хуулийн төсөл өргөн барих тов тогтоолгох тухай албан бичгийг хүргүүлээд байна. Хавсралт : 2 файл	
138	5.6.7.Гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлэн үр ашгийг нь дээшлүүлж, хил орчмын худалдааг хөнгөвчлөх зорилгоор хилийн боомт, хил орчмын дэд бүтцийг сайжруулж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор иргэд зорчих нөхцөлийг сайжруулж, олон	7. Замын-Үүд, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2017 - 2019	Улсын төсөв 349,5 сая төг	“Алтанбулаг”, “Замын-Үүд” хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажилд магадлал хийх ажилтай холбогдуулан “Орон тооны бус экспертүүдийн ажлын хэсэг байгуулах тухай” БХБ-ын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 177, 180 дугаар тушаал гарч, гүйцэтгэгч “Нью урбанизм” ХХК, “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ газар, БХТ-д 2019.11.08-ны өдрийн 03/4228 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Алтанбулаг”, “Замын-Үүд” хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гүйцэтгэж буй “Нью урбанизм” ХХК 2019.10.31-ний өдрийн №-ну/215, “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн” ОНӨААТҮГ 2019.10.11-ний өдрийн №02/480 тоот, “Бичигт” хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж буй гүйцэтгэгч “Идеал групп” ХХК эцсийн шатны тайланг БХТ-д 2019.12.06-ны өдрийн 046/2019 тоот албан бичгээр тус тус эцсийн шатны тайланг БХТ-д хүргүүлж тайлан хянагдсан. Замын-Үүд хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэл 2019.12.04-ний өдрийн 1/3630 тоот, Алтанбулаг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2019.12.06-ны өдрийн 1/3717 тоот албан бичгээр БХТ-өөс тус яаманд ирсэн бөгөөд тус тус хянагдаж байна. “Алтанбулаг”, “Бичигт”, “Замын-Үүд” хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг яамны ШУТТЗ-ийн хурлаар 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр, Сайдын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны хурлаар тус тус хэлэлцүүлэхээр төлөвлөгөөнд тусган батлуулаад байна. Хавсралт : 2 файл	100%
139	улс, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци болон дэд бүтцийн сүлжээнд хамрагдах үйл явцыг	8. Ханги, Бичигт, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр зэрэг хилийн боомтуудын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий	2017 - 2019	Улсын төсөв 68,1 сая төгрөг	Ханги, Бичигт, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр зэрэг хилийн боомтуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 841.8 сая төгрөгийг 2016-2020 оны төсөвт тусгуулахаар саналыг жил бүр хүргүүлдэг боловч санхүүжилт тусгагддаггүй. “Бичигт” хилийн боомтын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх 68.1 сая төгрөгийн санхүүжилтийг Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуульд тусган батлуулсан. Бусад хилийн боомтуудын батлагдсан хөгжлийн ерөнхий	100%

	эрчимжүүлж, гадаад худалдааны тааламжтай нөхцөлийг бүрдүүлнэ.	төлөвлөгөөг боловсруулах				төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай санхүүжилт тусгагдаагүй болно. "Бичигт" хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах зургийн 2018/66/СС/306 тоот даалгаврыг БХБ-ын сайд Х. Баделхан, Сангийн сайд, хилийн боомтын үндэсний зөвлөлийн дарга Ч.Хүрэлбаатар хамтран 2018.12.28-ний өдөр батлуулсан. Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 153 дугаартай гэрээг "Идеал групп" ХХК-тай 2018.07.19-ны өдөр байгуулж, ажлыг гүйцэтгүүлсэн. Тус хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын хүрээнд Сангийн яам, хилийн боомтын үндэсний зөвлөлөөс 2019.02.02-ны өдрийн 11/881 тоот албан бичгээр санал ирүүлснийг гүйцэтгэгч компанид 2019.03.01-ний өдрийн 06/734 тоот албан бичгээр холбогдох саналыг хүргүүлсэн. "Бичигт" хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж буй гүйцэтгэгч "Идеал групп" ХХК эцсийн шатны тайланг БХТ-д 2019.12.06-ны өдрийн 046/2019 тоот албан бичгээр тус тус эцсийн шатны тайланг БХТ-д хүргүүлж тайлан хянагдсан. Эцсийн шатны тайланг тус яаманд ирүүлээд байна. Хавсралт : 1 файл	
<b>ЗУРГАА. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРУУЛАХ ЗААЛТУУД</b>							
140	6.1.8.Цэвэрлэх байгууламжийг шинэчлэн хүчин чадлыг нэмэгдүүлнэ	1. Цэвэрлэх байгууламжийг шинэчлэн хүчин чадлыг нэмэгдүүлэх	2017 - 2019	1.069.3 сая төг		Архангай аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын гүйцэтгэгчээр "ЧММ" ХХК, БНТурк Улсын "ЭНТА ИНЖЕНЕРИНГ цэвэрлэх байгууламжийн угсралт" ХХК түншлэл шалгаран ажилласан. Хоногт 3000 м3 бохир усыг зохиомол биологи цэвэрлэгээний аргаар цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, 2019.10.15-нд байнгын ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл -100% Хавсралт : 2 файл	100%
141	6.2.3.Өлгий сумын төвийг 120 ортой хүүхдийн эмнэлэгтэй болгоно.	2. Зураг төсөл боловсруулж барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авах	2017 - 2018			Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 50 ортой хүүхдийн эмнэлэгийн барилгын ажлын зургийг "Сийз Архитектс" ХХК зохиож, барилгын ажлын гүйцэтгэгчээр "Эсба" ХХК шалгаран 2018 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байна. Барилгын ажлын явц 57 хувьтай 2020 онд дуусгана. Тухайн ажил нь Эрүүл, мэндийн сайдын багцад орсон ажил болно.	70%
142	6.3.6.Цементийн үйлдвэр байгуулж, баруун бүсийг хангана.	1. Цементийн үйлдвэр байгуулж, баруун бүс нутгийн хэрэгцээг хангах	2017 - 2020	900,0 сая төгрөг - Хувийн хэвшил		Баян-Өлгий аймагт "Өлгий-Цемент" ХХК-ийн цементийн тээрмийн үйлдвэр баригдаж, 42,5 -52,5 маркийн 150 тонн цемент үйлдвэрлэсэн. Баруун аймгуудад 1 тонн цемент 340000 төгрөг буюу 1 уут цемент 17000-18000 төгрөгөөр борлуулагдаж байсан бол энэ үйлдвэр ашиглалтад орсоноор 1 тонныг 260 мянган төгрөг буюу 1 уут цементийг 13 мянган төгрөгөөр борлуулсан байна. Барилгын	100%

					материалын үйлдвэрлэлд тусгай зөвшөөрөл олгох ажлын хэсгийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаас “Өлгий-Цемент” ХХК-д цемент үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгосон. Энэхүү үйлдвэр ашиглалтад орсоноор баруун бүсийн цементийн хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдээд байна. Хавсралт : 1 файл	
143	6.5.4.Алтай хотыг ундны цэвэр усаар хангаж байгаа өнөөгийн түвшинг бататган цаашид төгс шийдвэрлэх зорилгоор Завхан голоос аймгийн төв хүртэлх 50 км ус дамжуулах шугам хоолой шинээр татаж, дагалдах тоног төхөөрөмжийг суурилуулан, ус цэвэршүүлэх станцын хамт барих арга хэмжээ авна.	1. "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх	2017 - 2020	10.706.259.4 9 евро	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан 40 сая еврогийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд 14 сая еврогийн Австрийн хөнгөлттэй зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Тайшир-Алтай ус хангамж” төслийн хүрээнд Австри Улсын “Тиролер Рохре” ХХК-тай “Зураг төсөл-нийлүүлэлт-барилга угсралт”-ын ажлын гэрээ байгуулан ажиллаж байна. Барилга байгууламжийн зураг төслийн ажил 100 хувь дуусч, 2019 оны 4 дүгээр сарын 1-ны өдрийн 408/2019 дугаартай магадлалын дүгнэлт гарсан. Барилгын ажил 2019 оны 04 дүгээр сараас эхэлсэн. Төслийн хүрээнд 54 км ган хоолой угсрахаас 27 км хоолойг угсарсан. Ус цэвэршүүлэх станц, усан сан, өргөлтийн насос станц болон 14 метрийн гүнтэй ус авах цооногийн төмөр бетон цутгалтын ажил тус тус бүрэн дууссан. Нийт барилга байгууламжийн угсралтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус төслийн хүрээнд 10,706,259.49 еврогийн санхүүжилт хийгдсэн. Хавсралт : 2 файл	100%
144	6.7.10.Дархан хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.	1. Дархан хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	2016 - 2020	1.732.3 сая төг	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн хүрээнд 2018 онд цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж, батлуулсан. Дулааны 1,2 км хос шугам хоолойг барьж, дулааны 3-р насос станцын тоног төхөөрөмж болон цахилгаан тоноглолыг шинэчилсэн. “Дархан дулааны сүлжээ” ТӨХК-д 1 тэрбум 260,3 сая төг-ийн үнэ бүхий дулааны насос станц, цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамыг хүлээлгэн өгч, барилга байгууламжийн ашиглалтын ногоон гэрчилгээ олгосон. 2019 онд “Цагаан зуун” ХХК нь ф300 мм-ийн голчтой 1770 м шугам, 52 худгийн барилгын ажлыг, “Бридж констракшн” ХХК нь ф300 мм-ийн голчтой 290 м шугам, 13 худгийн барилгын ажлыг гүйцэтгэн, 2019	100%

					оны 08 дугаар сарын 30-ны өдөр тус тус ашиглалтад оруулсан. Техникийн шаардлага хангасан эксковаторыг Дарханы ус сувгийн байгууллагад 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн. Бохир усны насос станцыг шинэчлэх, нэмэлт шугам хоолойн ажлын зураг төслийг “Эрчим төсөл” ХХК боловсруулж, батлуулсан. Төслийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 75.6 хувьтай байна. Төсөл 2020 онд дуусна. Хавсралт : 4 файл	
145	6.8.13.Сайншанд сумын цэвэрлэх байгууламжид техникийн шинэчлэл хийнэ.	13. Аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулан, цэвэрлэгдсэн усыг цаашид үйлдвэрлэлийн технологи болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглахыг дэмжих	2017 - 2018	95,3 мянган ам.доллар - АХБ	"Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН 3388" төслийн хүрээнд Дорноговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын гүйцэтгэгчээр Бүгд Найрамдах Турк Улсын “Эйч Эн Си” компани шалгарч, 2018.12.28-ны өдөр гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг 2019.03.27-ны өдөр эхэлсэн. Цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг орон нутгийн ГХБХБ-ын газраас №БАЗ-БУ-02/2019 тоотой авсан. Биологи цэвэрлэгээний блокийн барилгын тэнцвэржүүлэх сангийн хэв хашмалын ажил, 2-р тунгаагуурын ханын арматурчлал, сараалжийн, дэд өртөөний барилгуудын гадна фасадын ажил, үйлдвэрийн барилгын гадна өрлөгийн ажил, лаг боловсруулах цех, уурын зуухны барилгуудын өрлөг, хучилтын цутгалтын ажлууд хийгдсэн. Гадна цэвэр, бохир усны шугамын ажил, Ар, Өвөршандын 4.4 км бохир усны коллекторын шугамын угсралтын ажлууд дууссан. Үйлдвэрийн барилгын 1-р давхрын ханын өрлөг, шалны цутгалтын ажлыг гүйцэтгэсэн. Нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьтай. Хавсралт : 1 файл	100%
146	6.10.7.Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, хүчин чадлыг нь нэмэгдүүлнэ.	1. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих	2017 - 2020	10.8 сая.ам. доллар - АХБ	АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо газрын суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН 3388” төслийн хүрээнд Өвөрхангай, Архангай, Өмнөговь, Дорноговь аймгуудын төвд ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байна. Архангай аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьж дуусган, аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/536 тоот захирамжаар байгуулагдсан комисс 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ажиллан, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан. Өмнөговь аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын хүрээнд биологи цэвэрлэгээний блок, технологийн шугам сүлжээний ажил, бохир усны 5,1 км шугамын угсралтын ажил, лаг боловсруулах цех, лагийн талбай, цахилгаан дамжуулах агаарын 10 кв-ын шугамын угсралт, цахилгааны дэд өртөөний	100%



					угсралтын ажлуудыг гүйцэтгэсэн. Үйлдвэрийн, механик цэвэрлэгээний блокын барилгын ажил дуусах шатандаа байна. Хавсралт : 3 файл	
147	6.11.4.Улиастай хотын цэвэрлэх байгууламжийг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1. Улиастай хотын 3000 м.куб/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, одоо ашиглаж байгаа газар доорх цэвэр-бохир усны шугам сүлжээний шинэчлэлтийн зураг төсвийг хийж, ажлыг эхлүүлэх	2017 - 2020	-	Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх “Аймгуудын төвд бохир ус цэвэрлэх байгууламж барих /Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс/” ажлын гүйцэтгэгчийн тендерийг 2019.06.26-2019.10.18-ны өдрийг хүртэл зохион байгуулсан. Уг тендерт оролцогч Польш Улсын “ВЕКТО” компанийн толгойлсон түншлэл тендер ирүүлсэн бөгөөд Тендерийн баримт бичгийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэхүү тендерт Бүгд Найрамдах Польш Улсын Сангийн яамнаас олгосон Батламж бичигтэй Польш Улсын компаниуд оролцох эрхтэй ...” гэж заасан ерөнхий шаардлагыг хангаагүй тул уг тендерээс татгалзсан шийдвэрийг Үнэлгээний хорооны 2019.10.18-ны өдрийн хурлаас гаргасан. Уг шийдвэрийг тендерт оролцогч түншлэлд 2019.10.25-ны өдөр 03/3999 тоот албан бичгээр мэдэгдсэн. Уг албан бичгийг Монгол Улсын Сангийн яам, Польш Улс дахь Монгол Улсын элчин сайдын яаманд цахим шуудангаар нэгэн зэрэг хүргүүлсэн болно. Иймд Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу зээлийн гэрээг сунгах хүсэлтийг Сангийн яаманд 2019 оны 08 дугаар сард хүргүүлээд байна. Хавсралт : 5 файл	100%
148	6.19.6.Цементийн үйлдвэр барина. /Жаргалант сум/	1. Цементийн үйлдвэр барих /Жаргалант сум/	2017 - 2018	2.122 сая төг	Ховд аймгийн Буянт суманд “Ховд эко цемент”-ийн үйлдвэрийн барилгын ажил 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр нээлтээ хийсэн. Засгийн газрын 21:100 хөтөлбөрт багтсан энэхүү үйлдвэр нь жилд 300 мянган тн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн цементийн хэрэглээг 100 хувь хангахаар төлөвлөж байна. Тус компани цементийн үйлдвэрийн ТЭЗҮ-ээ зохих шатны хурлуудаар хэлэлцүүлэн зөвлөмжийг төсөлдөө тусгаснаас гадна байгаль орчны нарийвчилсан үнэлгээг БОАЖЯ-аар батлуулсан. Мөн Ховд аймгийн Буянт суманд “Ховд эко цемент”-ийн үйлдвэрийн барилгын ажил 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр нээлтээ хийсэн. Засгийн газрын 21:100 хөтөлбөрт багтсан энэхүү үйлдвэр нь жилд 300 мянган тн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн цементийн хэрэглээг 100 хувь хангахаар төлөвлөж байна. Тус компани цементийн үйлдвэрийн ТЭЗҮ-ээ зохих шатны хурлуудаар хэлэлцүүлэн зөвлөмжийг төсөлдөө тусгаснаас гадна байгаль орчны нарийвчилсан үнэлгээг БОАЖЯ-аар батлуулсан.	100%

149	6.19.8. Цэвэр, бохир усны 15 км газар доорх шугам шинэчилнэ. /Жаргалант сум/	1. Цэвэр, бохир усны 15 км газар доорх шугам шинэчлэх /Жаргалант сум/	2018 - 2019		Ховд аймгийн Жаргалант суманд "Цэвэр, бохир усны 15 км шугамын шинэчлэлтийн ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын эхний ээлжийн ажил эхлүүлэх"- ажлын хүрээнд 2017 онд 3.2 км цэвэр, бохир усны шугам сүлжээ барьсан. Энэ ажлын үргэлжлэл болох "Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Ховд, Жаргалант сум/" төсөл, арга хэмжээ нь 2018 оны Төсвийн тухай хуулийн XII.1.50-д батлагдаж, 8.2 км цэвэр усны шугам, 6.3 км бохир усны шугам барих ажлыг "Ховдын-Өргөө" ХХК гүйцэтгэсэн байна.	100%
150	6.21.3.Хэнтий аймгийн Чингис хотод цэвэрлэх байгууламж шинээр барина.	1. Хэнтий аймгийн Чингис хотод цэвэрлэх байгууламж шинээр барих	2017 - 2020	300,0 мянган ам.доллар - АХБ	АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН 3388 төсөл"-ийн хүрээнд Хэнтий аймгийн төвд цэвэрлэх байгууламж шинээр барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж 2019.08.22-ны өдөр гэрээ байгуулж, барилга угсралтын ажил 2019 оны 8 дугаар сарын 30-ны өдөр эхэлсэн. Энэ ажлын хүрээнд ЦДАШ-ын угсралтын ажил бүрэн дууссан, түр цахилгаан хангамжийн зөвшөөрөл авсан. Захиргааны, дэд өртөөний барилга, харуулын барилгуудын өрлөг, хучилтын ажлууд хийгдэж дууссан. Хүйтний улирлын түр зогсолт хийсэн. Гэрээ ёсоор ажлын гүйцэтгэл 10 хувьтай байна. Хавсралт : 1 файл	100%